Хүний Эрхийн Үндэсний Комисс

Хүүхдийн Төлөө Үндэсний Газар

Монголын хүүхдийн Эрхийн Төв

# Хүүхдийн эрхийн төлөв байдлын судалгааны нэгдсэн тайлан дүгнэлт

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Улаанбаатар хот

2003 он

ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН СУДАЛГААНЫ
ТАЙЛАНД ХИЙСЭН НЭГДСЭН ДҮГНЭЛТ САНАЛ

2003 оны 04.05

Хүүхдийн эрхийг хамгаалах тухай Монгол улсын хуулийн хэрэгжилтийн байдалд үндэслэн Хүүхдийн эрхийн төлөв байдлын судалгааг ХЭҮК, ХТҮГ хамтран 2003 оны 2 дугаар сард үндэсний хэмжээнд явуулж дүгнэж байна.

Судалгаанд Орхоноос бусад аймаг, нийслэлийн тайлан нэгтгэгдсэн бөгөөд орон нутаг дахь ХЭҮК-ын төлөөлөгч, Хүүхдийн төлөө төв холбогдох байгууллагууд хамтран ажилласан болно.

ХТҮГазар аймаг, нийслэлийн тайланд дүн шинжилгээ хийхдээ хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийн агуулгын дагуу хүүхдийн эрхийн асуудлыг үндсэн дөрвөн бүлэгт авч үзлээ. Үүнд:

- Хүүхдийн эсэн мэнд амьдрах эрх
- Хүүхдийн сурч боловсрох, хөгжих эрх
- Хүүхдийн хамгаалуулах эрх
- Хүүхдийн нийгмийн амьдралд оролцох, мэдээлэл хүртэх эрх

Дээрх чиглэлээр тайланд шинжилгээ хийхдээ ихэнхдээ орон нутагт байгаа тулгамдсан нийтлэг асуудал,шийдвэрлэхэд анхаарах зүйлийг илүү нэгтгэж аймаг бүрийн тайлан, онцлог үйл ажиллагааг сурч боловсрох эрхийн хэрэгжилтээс бусад хэсэгт дурдсангүй .

**А. Хүүхдийн эсэн мэнд амьдрах эрхийн хэрэгжилтийн талаар**:

Монгол Улсын Засгийн газар, ДЭМБ, НҮБ-ын Хүүхдийн сан, Хүн амын сан, болон хандивлагч, түншлэгч орнуудын олон талын дэмжлэгтэйгээр эх хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, өвчлөл, эндэгдлийг бууруулах, эцэг эхийн эрүүл мэндийн тусламж хайх мэдлэг, чадварыг дээшлүүлэх, хүүхдийг дархлаажуулах, хөхүүлэх, хоол хүнсний хангамжийг сайжруулах олон талт арга хэмжээг хэрэгжүүлж байгаа нь хүүхэд, өсвөр үеийнхний эрүүл мэндийг сайжруулахад томоохон хувь нэмэр болж байна.

Эрүүл мэндийн бүртгэлзүйн мэдээгээр 10000 хүүхдэд ногдох өвчлөл нялхсын хувьд 48.5, нэгээс дөрөв хүртлэх насанд 72.3, тавaас арван таван насанд 126.7, арван зургаагаас арван есөн насанд 66,8 тохиолдож байна. Мөн ерөнхий боловсролын сургуулийн 1000 сурагч тутмаас 678,2 нь ямар нэг архаг өвчтэй, .Өсвөр насны охидын 9 хувь нь жирэмсэлсэн судалгааны дүн мэдээ байна.

Хүүхдийн эндэгдэл буурч байгаа ч ураг нярайн эндэгдэл Баян-Өлгий , Завхан , Дархан , Дорноговь , Ховд , Дорнод ,Баянхонгор аймагт; нялхсын эндэгдэл Дорнод , Баян-Өлгий , Өмнөговь, Ховд , Увс , Говь-Алтай , Завхан , Хэнтий аймаг ,Улаанбаатар хотод; тав хүртлэх насны хүүхдийн эндэгдэл Дорнод , Баянхонгор ,Ховд ,Увс , Дархан , Говь-Алтай , Хөвсгөл , Баян-Өлгий аймагт улсын дунджаас дээгүүр байна. Амьдралын түвшин доогуур өрхийн хүүхэд 2.5 дахин илүү өвчилж, 3 дахин илүү эмнэлэгт хэвтэж, мөн тэдий тоогоор эндэж байна.

Хүүхэд, өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын орчин нөхцөл, технологийг сайжруулахад хүрэлцэхүйц хэмжээтэй хөрөнгө оруулалтыг шаардаж байна. Хүүхэд, өсвөр үеийнхэнд үзүүлж буй эрүүл мэндийн анхан шатны тусламж шаардлагын түвшинд хүрч чадаагүй , хүүхдийн эмч бэлтгэх, мэргэшүүлэх бодлого алдагдсан байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Сүүлийн арваад жилд хүүхдийн эмчийн тоо 3,5 дахин цөөрсөн төдийгүй нийт аймгийн дөнгөж 25 хувь нь хүүхэд, өсвөр үеийн эрүүл ахуйч эмчтэй байна.

Хүүхдийн эсэн мэнд амьдрахын үндэс болсон хоол хүнсний чанар, хүрэлцээ, хангамж ДЭМБ-ын зөвлөмжийн нийтлэг жишиг хэмжээнд хүрэхгүйгээс тав хүртлэх насны хүүхдэд тураал 12.5 хувь, өсөлтийн хоцрогдол 24.6 хувь, Д аминдэм дутлын рахит 32.1 хувь, цус багадалт 40.2 хувь тохиолдож байна. Мөн таваас дээш насны хүүхэд, өсвөр үеийнхний 16 хувь нь өсөлтийн хоцрогдолтой, 21.4 хувь нь иод дутлын эмгэгтэй байна.

Хүүхэд, өсвөр үеийнхэнд үйлчлэх байгууллагын орчин, тоног төхөөрөмж, ном сурах бичиг, хичээлийн хэрэгсэл эрүүл ахуйн жишиг шаардлагад нийцэхгүй байгаагаас тэдний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж, өвчин эмгэгт өртөх эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Байгалийн гамшиг, хүрээлэн буй орчны бохирдол, хүний ухамсарт үйлдлээс үүдсэн эрсдэлт байдлаас хүүхэд, өсвөр үеийнхний эрүүл мэнд, амь нас хохирох тохиолдол гарсаар байна. Өсвөр үеийнхний дунд тохиолдох осол гэмтэл, цочмог хордолт насанд хүрэгчдийнхээс 2 дахин илүү байна.

Хүний эрхийн Үндэсний Комисс, ХТҮГ-аас явуулсан Хүүхдийн эрхийн төлөв байдлын 2003 оны нэгдсэн судалгааны дүнгээс харахад: Судалгаанд оролцсон насанд хүрэгчдийн 25.2 хувь нь эрүүл мэндийн салбарт хүний эрх илүү зөрчигддөг гэхэд хүүхдүүдийн 19.7 хувь нь эрүүл мэндээ хамгаалуулах эрх зөрчигддөг гээд хүүхдэд төрөөс үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээ ямар байгааг тэдний 41.8 хувь нь учир дутагдалтай, 24.2 хувь нь хангалтгүй , 30 гаруй хувь боломжийн гэж хариулжээ.

Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн байдалд тулгуурлан хийсэн дээрх үйл ажиллагаанаас хүүхдийн эсэн мэнд амьдрах, эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг хэрэгжүүлэхэд анхаарах нийтлэг асуудал нь **:**

Хүүхдийн амьдрах орчинтой холбоотойгоор:

- Говийн аймаг сумдын ундны усны хатуулаг, эрдэсжилт их,
- Хөдөөд нарийн мэргэжлийн (хүүхэд, шүд зэрэг) эмчийн хүрэлцээ муу
- Хүүхдийн байгууллагын халаалтын систем муу анги танхим маш хүйтэн
- дотуур байр, халамжийн төвийн эрүүл ахуй ариун цэврийн хангамж муу,
- Хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй орчинд тавих эцэг эхийн анхаарал сул

Гэр бүл, нийгмийн сэтгэлзүйтэй холбоотойгоор:

- Хүүхдийн асуудалд бага анхаардаг, хойш тавьж цаг алддаг
- Хүүхдийг үл тоомсорлодог хандлага
- Хүүхдийн эрхийн тухай насанд хүрэгчдийн ойлголт хангалтгүй
- Хүүхдэд хандсан үйлчилгээний хүрээ бага, чанар хангалтгүй
- Эрүүл мэндийн салбарынхны хүнд суртал, авилгалд автсан байдал

Эдийн засгийн бэрхшээлтэй холбоотойгоор:

UFH.MN
СУДАЛГААНЫ САН

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эмчилгээ сувиллын зардал өндөр, хүрээ хомс
- Хүүхдэд зориулсан хоол хүнсэнд бага цаг зарцуулдаг
- Бага насны хүүхдийг идэвхтэй хооллох арга дутмаг
- Сургуулийн хүүхдийн хоол хүнс хангалттай бус
- Гэнэтийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх хандлага муу
- Хүүхдийг витамижуулах, вакцинжуулах ажил хоцордог

Мэдээллийн хүртээмжтэй холбоотойгоор:

- БЗХӨ-өөс сэргийлэх, нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох ажил хөдөө орон нутагт удаашралтай
- Орон нутгийн хүүхдийн зарим байгууллагын үйл ажиллагаанд тавих олон нийтийн хяналт сул
- Ажиллах боловсон хүчний бэлтгэгдсэн байдал хангалтгүй

байгаа зэрэг нь хүүхдийн эсэн мэнд амьдрах, эрүүл мэндээ хамгаалуулах эрхийн хэрэгжилтэнд сөргөөр нөлөөлж байна.

**Б. Сурч боловсрох, хөгжих эрхийн хэрэгжилтийн талаар**:

**1. Архангай аймаг**

Нэн ядуу өрхийн хүүхдэд зориулсан хичээлийн хэрэгслийн 4000 гаруй хүүхдэд олгож албан бус сургалтанд Японы Энхтайвны салхи байгууллагын дэмжлэгийг нэлээд авсан байна. Эмзэг бүлгийн хүүхдийг дотуур байранд авч сурах боломцоог дэмжихэд анхаардаг байна.

**2. Баян-Өлгий**

Тус аймагт амьдарч байгаа 50.0 мянга хүүхдээс Ерөнхий боловсролын 36 сургуульд 21567 хүүхэд, хүүхдийн 23 цэцэрлэгт 2020 хүүхэд хүмүүжиж байна. Энэ оны хичээлийн жилд сурч буй хүүхдүүдийн тоо өмнөх оныхоос 1268-аар нэмэгдсэн байна.

Жил бүрийн төсөв, төлөвлөгөөнд боловсролын салбарт шаардагдах хөрөгийг ахиу төлөвлөхийг зорьж дэвшүүлсэн зорилтуудаа дэс дараатайгаар хэрэгжүүлж байна.

2001-2002 онд Казахстан улсад хэвлэгдсэн 6400 сурах бичгийг Казахстан улс зардлыг нь хариуцаж аймагт хүргүүлж ирүүлсэн байна.
Үүнээс гадна ЕБС-ийн 6 сурах бичгийг БСШУЯ-ны хөрөнгөөр хэвлүүлж сургалтад ашиглаж байна. Сурах бичгүүдийг шинэчлэх, утга агуулгыг баяжуулах ажил жил бүр хийгдэж байна.

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын материаллаг баазыг бэхжүүлэхэд анхаарч Английн хүүхдийг ивээх сангийн төслөөр бүрэн тоноглогдсон эсгий гэр цэцэрлэг 5, Боловсрол Соёлын Төвийн дэргэд "Сургуулийн өмнөх боловсрол" кабинет шинээр байгуулан арга зүйн сургалтад ашиглаж байна.

Сургуулиудын номын сангийн баяжилтад анхаарч 'Гэгээрэл ' төв байгуулж явуулын багш ажиллуулжээ.

Бичиг үсэггүй хүүхдийн тоо 2000 онд 2962, 2001 онд 1619, 2002 онд 1269 болж 1600 гаруй хүн бичиг үсэгтэй боллоо.

Цэцэрлэгт хамрагдсан хүүхдийн тоогоор улсын дунджаас доогуур байгаад дүгнэлт хийж салбар зөвлөл байгуулагдлаа.

3.Баянхонгор аймаг

UIH.MN

Аймгийн хэмжээнд 3-7 насны хүүхдийн 20 орчим хувь нь сургуулийн өмнөх боловсролд, 8-15 насны хүүхдүүдийн 82.3% нь сургуульд хамрагдаж байна. Сүүлийн жилүүдэд мал ихээр хорогдсонтой холбогдон сургууль завсардалтын хувь буурч байгаа хэдий ч олон жил сургууль завсардсан хүүхдүүд ерөнхий боловсролд хамрагдах нь муу байна.

Хэдийгээр малаа алдсан айд өрхүүдийн хүүхдүүд сургуульд суралцах тоо өсч байгаа ч анги танхимын хүрэлцээ муу, халаалт муугаас болж хичээлдээ гадуур хувцастай суух явдал гарч байна. Мөн биеийн тамрийн хичээл, секц дугуйланд орохдоо хүүхдүүд зориулалтын хувцасгүй, гадаа хичээллэж байна. Галуут сумын сургуульд 2 жилийн өмнө 11 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар халаалтын ёиётем суурилуулсан боловч үр дүнгүй болсон явдал гарлаа.

Засгийн газраас дотуур байрыг төлбөргүй болгох шийдвэр гаргасан нь сургууль завсардалтын тоог бууруулсан ч дотуур байрны ачаалал ихэслээ. Нэг жижиг өрөөнд 4-6 хүүхэд шахцалдан байрлаж байгаа бөгөөд зарим тохиолдолд нэг айлын 2 хүүхдийг нэг оронд хуваарилж байна. Мөн

Аймгийн төвд 1455 хүүхэд хэвлэл захиалж байгаа нь нийт хүүхдүүдийн дөнгөж 6.8% болж байна.

Нийгмийн эмзэг бүлгийн болон тусгай хэрэгцээт боловрол шаардлагатай хүүхдүүдийн 60 гаруй хувь нь боловсролын үйлчилгээнд хамрагдаж байгаа ч 2000 гаруй хүүхэд сургуулиас гадуур байна. МННХ, АХИС, ЮНИСЕФ, АЙФО зэрэг байгууллагуудын тусламжтайгаар боловсролын салбарт 12 төсөл, хөтөлбөр хэрэгжүүлжээ.

2000 оноос АХИС-ийн дэмжлэгтэйгээр 9 суманд нүүдлийн гэр цэцэрлэгийг ажиллуулж эхлээд байна.

Хүүхдүүдэд чөлөөт цагаа өнгөрүүлэх газар бараг байхгүй бөгөөд хүүхдүүд ихэнх цагаа байрны подволд байрлах компьютер тоглоомын газар, киноны газруудад өнгөрүүлдэг болжээ.

Хүүхдүүдийн дунд хийсэн судалгаанаас сургуулийн зүгээс элдэв дарамт шахалт учруулдаг гэж гарсан бөгөөд нэг сургуулийн хэсэг хүүхдүүд сонирхлын бүлэг байгуулахаар сургуулийн захиргаандаа хандахад нь дээд албан тушаалын хүнээс зөвшөөрөл авч ирэхийг шаарджээ. Мөн нэгэн сургуульд амьтан судлалын багш нь тухайн ангитай зөрчилтэй байсан учраас 14 хоног өөрийнхөө оронд мэргэжлийн бус хүнээр хичээл заалгуулсан тохиолдол гарсан байна.

Насанд хүрэгчдийн дунд хийсэн судалгаанаас үзэхэд хүүхдийн эрхийн зөрчил хамгийн их газрын 2-рт 58%-иар боловсролын салбарын онцолжээ.

**4. Булган аймаг**

Аймгийн хэмжээнд сургуульд хамрагдалт 91%-тай байна. Мөн өнгөрсөн жилд аймгийн хэмжээнд багш дутагдалтай учир захиалгаар оюутан сургаж байна.

МСҮТ-д 9 мэргэжлээр 450 хүүхдийг суралцуулж байгаа бөгөөд тус төвийн дотуур байры зардал зарим ажилтны буруугаас 50% дутуу ирж хүндрэл учраад байна.

Хөдөөгийн хүүхдүүдэд зориулсан компьютер, мэдээллийн хүртээмж бага, сургуулийн номын сангийн фондод 80-90% нь хүрэлцээ муутай сурах бичиг, 10-20% нь хуучирсан номууд байна. Сурагчдын хувьд хичээлийн бус цагаар авъяас чадвараа хөгжүүлэх боломж муу байгаа бөгөөд багш нар аливаа дугуйлан хичээллүүлэхдээ заавал мөнгө авдаг гэжээ. Үүнд: тооны дугуйлан гэхэд 1000₮, бүжгийн дугуйлан 3000₮ гэх мэтээр төвийн дугуйлангуудад 5000₮ гэсэн жишиг ханш тогтоод байна.

Мөн элдэв баяр ёслол далимдуулан хүүхдүүдээс мөнгө, зүйлс татах нь ихсэж байгаа бөгөөд үсэглэлийн баярын үеэр 5000₮ хураалгаад дээр нь нэг жигнүүр бууз,

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

халуун сав цай авч очдог болжээ. Судалгаанаас үзэхэд мөнгө, эд зүйл хураадаг явдал байнга байдаг гэж 10% нь, хаяа байдаг гэж 68.5% нь хариулсан байна.

Багш нарын хүүхдүүдэд ялгавартай ханддаг эсэхэд судалгаанд оролцсон хүүхдүүдийн 65.3% нь ТИЙМ гэж хариулжээ.

Тус аймагт хүүхдүүдийн цагаа өнгөрүүлэх газар өдрөөс өдөрт багасан харин томчуудын баар цэнгээний газар нэмэгдсээр байна.

Багш нар хүүхдүүдийг доромжлох явдал байдаг бөгөөд зоддог багш нарч байна. Нэг ангид багш нь ижил цагаан цамц өмсөж ирэхийг шаарддаг бөгөөд нэгэн удаа цөөн хүүхэд өөр хувцастай ирэхэд бүх хүүхдүүдийг хувцасыг нь тайлуулан нүцгэн биеэр нь суулган хараад одоо ингээд жигдэрлээ гэж сэтгэл хангалуун болох тохиолдол гарчээ. Зарим тохиолдолд цагаан цамцгүй ирвэл 100₮-өөр торгох үе гардаг бөгөөд хичээлээс хоцорлоо гэж 500₮ авдаг байна.

Мөн ном хувилан тараагаад заавал авахыг тулгадаг бөгөөд авахгүй бол шалгалт шүүлэгт унагана гэдэг ажээ. Тус аймагт хүүхдийн эрхийг хамгийн их зөрчигчид багш нар гэж 45.3% нь үзсэн байна.

Дотуур байранд 1750 хүүхэд амьдарч байгаа бөгөөд дотуур байрны зөөлөн эдлэлийг шинэчлэхэд зориулан 4 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн боловч хүүхдийн ширээ сандал, аяга таваг, гал тогооны хэрэгсэл гэх мэт зүйлс дутагдалтай байсаар байна.

**5. Говь-Алтай аймаг**

Хүүхдүүд ядуу зүдүү байдлаас болж сургууль завсардах, шалтгаан их байна. Хичээлийн хэрэгсэл, хувцас муу, учраас үеийн хүүхдүүдээс ичиж хичээлээс хөндийрэх, зарим багш нарын хүүхдэд ялгавартай хандах байдлаас болж сургууль завсардах нь мөн их байна.

Нэн ядуу амьдралтай хүүхдүүдэд сурч боловсрох нөхцөлийг бий болгох үүдээс Есөнбулаг сумын Засаг даргын захирамжаар өнчин ядуу 157хүүхэдийг албан байгууллагуудад хариуцуулан өгсөн.

Сургуулийн хүүхдүүдэд тохиолдож буй бэрхшээлүүд /багш, сурагчдын дунд хийсэн бүлгийн ярилцлагын тэмдэглэлээс/:

- Хөдөөгийн хүүхдүүд мэдээллээр маш дутмаг байна.
- Тоног төхөөрөмж хангалтгүй.
- Сүүлийн үед хүүхдүүдэд элэгдэж хуучирсан, ашиглалтын хугацаа дууссан ном өгч байна.
- Өвлийн улиралд номын сан ажилладаггүй.
- Оройн цагаар цахилгаан ирдэг гэвч тэр үед нь олон ангит кино, реклам хоёр л гардаг.
- Манай сургуульд гэхэд Үндсэн хууль, хүүхдийн эрхийн хууль, гэрээ, конвенци байхгүй.
- Сургууль, гэрийн орчинд хөгжих боломж муу байдаг.
- Төвд уралдаан тэмцээн зохиогдох боллоо гэхэд удирдамж нь хоцорч эсвэл цаг тулган ирдэгээс оролцож чадахгүй тохиолдол гардаг.
- Багш нар хүүхдүүдийг загнаж, зодох дарамтлах явдал байдаг. /Сурлагадаа муу байна гэж доромжилж зоддог, анги төгсөх ахлах ангийхнийг багш нар архи авч өгөөд дүнгээ гаргуул гэдэг… /
- Дотуур байранд том хүмүүс орой ирж агсам тавьдаг. Энэ байдлаас болж зарим хүүхэд дотуур байранд байхаас татгалздаг.
- Сургууль завсардах хэд хэдэн шалтгаан байдаг. Амьдралын боломж муугаас хувцас, хэрэгсэл тааруу, багш нар хэл амаар доромжлох, үеийнхэндээ хэт их шоглуулах гэх мэт.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн хүрээнд доорхи зөрчлүүд гардаг байна. Үүнд:

1. Мөнгө, эд зүйл шаардах – 85.7%
2. Ямар нэгэн байдлаар хүүхдэд ялгавартай хандах – 35.7%
3. Дарамтлах – 60%
4. Хүч хэрэглэх – 22.5%

Хүүхдүүд чөлөөт цагаа зөв, зохистой өнгөрүүлэх нөхцөл боломжийн хувьд:
1. Сайн -13%   2. Дунд – 22%   3.Муу – 65% гэж гарчээ.

**7.Дархан-Уул аймаг**

Аймгийн хэмжээнд сургуулийн насны хүүхэд 22175, сургуулийн өмнөх насны хүүхэд 7434, сургууль завсардсан хүүхэд 59 байна. Гэвч аймгийн Хүүхдийн төлөө төв, Хүүхдийн эрхийн төвийн гаргасан сургууль завсардсан хүүхдийн тоо их зөрүүтэй байдаг бөгөөд нөгөө нэг тоо нь 827 юм байна.

Аймгийн Засаг дагын захирамжаар 2000 онд хүүхдийн урлаг соёлын асуудлыг дэмжихэд зориулан 1,650,000 төгрөг, 2001 онд 8,942,666 төгрөг, 2002 онд 77,791,800 төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна.

2002 оны байдлаар ЕБС-ийн 1 хүүхдэд зарцуулагдаж байгаа жилийн зардал нь 102.8 мянган төгрөг, цэцэрлэгийн 1 хүүхдэд зарцуулагдаж байгаа жилийн зардал 179.1 мянган төгрөг байна.

**8. Дорноговь аймаг**

Аймгийн хэмжээн 0-7 насны 7985, 8-16 насны 11809 хүүхэд байна. Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2002 оны 3-р хуралдаанаар "Өрхийн амжиргааны чадавхийг дэмжих хөтөлбөр"-ийн хүрээнд дараах арга хэмжээг авсан.

- Мэргэжлийн багш дутагдалтай байгаа сумдад мэргэжлий 38 багш гэрээгээр ажиллуулж багшийн хангалтыг 96.7%-д хүргэсэн байна.
- Сургууль завсардсан хүүхдүүдийг сургалтад хамруулах ажил 2001 онд 94.2%, 2002 оны жилийн эцсийн байдлаар 94.6%-тай байна.
- Нэн ядуу болон ядуу өрхийн хүүхдүүдийг халамжийн бүлэгт хамруулах ажлын хүрээд 2001 онд 150, 2002 онд 180 хүүхдүүдийг тус тус оруулжээ.
- 2001 онд эмзэг бүлгийн 716 хүүхдэд, 2002 онд 1300 хүүхдэд хичээлийн хэрэгсэл олгосон байна.
- Сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөр хэрэгжиж эхэлснээр 2000 онд аймгийн цэцэрлэгт хамрагдалт 22%-тай байсан бол өдгөө 32.6%-д хүрч, сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт 45.6%-д хүрсэн байна.
- Замын-Үүд суманд орон нутгийн хөрөнгө оруулалтаар /115 сая төг/ 100 хүүхдийн хүчин чадал бүхий цэцэрлэгийн барилга барьж ашиглалтад оруулсан нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтыг нэмэгдүүлэхэд дөхөм болсон.

Хүүхдийн боловсролын талаар зарим эгэн судалгааны дүнгээс харахад сургуулийн өмнөх болон ЕБС-н хүрээнд мөнгө, эд зүйл шаарддаг шаарддаг гэж 54,5% нь хэлсэн байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**9. Дорнод**

ерөнхий боловсролын сургуулийн хамран сургалт 89.8%- тай байна.

Сургуулийн дотуур байрны хүрэлцээг сайжруулах арга хэмжээ авсанаар энэ жил 855 хүүхэд байрлаж байгаа нь өгөрсөн жилийнхээс 22.3%-иар нэмэгдсэн байна.

Сумдын ерөнхий боловсролын сургуулиуды материаллаг бааз, барилга, түүний дотоод орчин, тоног төхөөрөмж зэрэг муудсан нь сургалтын чанарт нөлөөлж байна.

Сургуулийн хүчин чадал хүрэхгүй байна гэсэн шалтгаанаар 9-р ангид элсэн суралцах хүүхдийн тоог хязгаарлах, бусад сургуулиас шилжин ирж байгаа хүүхдийг авахгүй байх хандлага байдаг бөгөөд үүнд доорх арга хэмжээг аван зохицуулжээ.

Дорнод аймгийн хүүхдүүдийн дунд хийсэн судалгаанаас үзэхэд 46.9% нь сурч боловсроход ямар нэгэн бэрхшээл байна гэж үзжээ. Мөн багш нар сурагчдад ялгавартай ханддаг гэж нийт судалгаанд оролцогчдын 53.5% нь үзсэн байна.

**10. Дундговь**

Дундговь аймгийн хувьд хүүхдийн хөгжих эрхийг дараах шалтгаанаар зөрчигдөж байна гэж үзжээ. Үүнд:

- Багш нар хүүхдийг дарамталдаг
- Сурах бичиг байдаггүй
- Хүүхдийн авяас чадварыг төрөөс дэмждэггүй
- Номын фонд байдаггүй
- Хүүхдэд зориулсан тусгай сургууль байдаггүй
- Оюуны хомсдолтой, тахир дутуу, саажилттай хүүхдүүд ЕБС-д сурах боломжгүй
- Хүүхдий сурах орчин муу
- Сургуульд санхүү төсөв мжж учир хүүхдүүд өөрсдөө их зүйлийг хийдэг
- Багш нарын сургалт муу, мэргэжлийн багш нар цөөн
- Багш ар мөнгө, эд зүйл их авдаг гэх мэтийг тоочжээ.

Мөн хүүхдийн хөгжих эрхийн зөрчил тус аймагт 82.5% байна гэж үзжээ.

Судалгаанаас үзэхд тус аймагт хүүхдийн эсрэг хүчирхийлэлийг багш нар үйлддэг гэж 81.3% нь үзсэн бөгөөд хамгийн их хүчирхийлэлтэй салбар нь 81.3% нь сургууль, 6.9% нь цэцэрлэг гэжээ.

Судалгаанд оруулснаар хүүхдийн сургууль завсардалт 46.5% нь эдийн засгийн, 17.4% нь эцэг эхийн хандлагаас, 13.9% нь эрүүл мэндээс, 11.60% нь багшийн хандлагаас, 10.4% нь цаг зуурын хүндрэлээс шалтгаалдаг гэжээ.

**11. Завхан аймаг**

Аймгийн хэмжээнд сургуулийн насны нийт хүүхдийн 94% нь сургуульд хамрагдаж байна.

Судалгаанаас үзэхэд хүүхдийн эрхийн зөрчил хамгийн их байдаг салбарын 2-рт боловсролын салбар бичигджээ.

**12. Орхон аймаг**

Тайлан ирээгүй.

**13. Өвөрхангай**

2002 он байдлаар сургуулийн насны 23608 хүүхэд байгаагаас 19008 хүүхэд сургуульд суралцаж 4600 хүүхэд сургууль завсардсан байна. Сургууль завсардса хүүхдүүдийн 1667 нь огт суралцаагүй, 2933 нь суралцаж байгаад завсардсан хүүхдүүд ажээ.

Сургууль суралцахад хүүхдүүдэд тулгардаг бэрхшээлүүд нь:

- Сурах орчны хувьд хөдөөгийн сургууль бүү хэл, аймгийн төвийн сургуулий байдал тун хэцүү.
- 1-р ангид нэг ширээнд 4-үүлээ шахцалдан сууж, ном сурах бичгээ дундаа хэрэглэдэг.
- Анги танхим хүрэлцээгүйгээс хичээлийн бус цагаар чөлөөт цагаа өнгөрүүлэх ая тухтай орчин байдаггүй.

Мөн ядуу өрхийн хүүхдүүдийн хувьд хувцас, хэрэгсэл муугаас болж сургууль завсардахад хүрдэг бөгөөд хүүхдүүдийн сургууль завсардах бас нэгэн шалтгаан нь сургуулийн зүгээс баяр, ёслол, анги танхим гэж мөнгө, эд зүйл нэхэх явдал ажээ.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Сургуулийн зүгээс мөнгө, эд зүйл шаардах явдалд 13,4% нь ТИЙМ гэж, 69,0% нь ХААЯА хэмээн хариулжээ.

**14. Өмнөговь**

Аймгийн хүүхдийн төлөө төв нь “Малчин хүүхдийн боловсрол” төслийг 6 дахь жилдээ хэрэгжүүлж зөвхөн 2002 онд 8.9 сая төгрөг зарцуулсан болсон.

Сургуулийн орчинд дараах зөрчлүүд ажиглагджээ. Үүнд:

- Сургуулийн ангийн засварт зориулан эцэг эхээс жил бүр мөнгө хуримтлуулдаг.
- Сурагчдын дунд зохиогдох ихэнх тэмцээн уралдааны урамшуулалыг ихэнхдээ бооцоо мэтээр хуримтлуулдаг
- Хүрмэн сумын сургууль дээр суралцагчдын хичээл тасалсан болон хичээлээс чөлөө авсны төлбөрийг сурагчид, эцэг эхчүүдээс авч байсан нь илэрсэн учир холбогдох эрх бүхий байгууллагад мэдэгдэж арга хэмжээ авахуулсан болно.
- Улирал дуусах жилийн эцсийн дүн гарах үед сурагчид үнэлгээ авах ба үнэлгээ ахиулах зорилгоор багшийн бэлтгэх материалыг олшруулах,хийх мөн үр дүн муутай рефератыг шивэх, олшруулах зэрэг нь сурагчдыг эдийн засгийн хүндрэлд оруулж тэдний эрхийг ноцтойгоор зөрчиж байгаа байдал ихэнх сургуульд ажиглагдаж байна.

**15. Сүхбаатар аймаг**

Насанд хүрэгчдийн дунд хийсэн судалгаанаас үзэхэд хүүхдийн эрх хамгийн ихээр зөрчигддөг газарт сургууль 29.0%-иар орсон бөгөөд ерөнхий боловсролын сургуулийн хүрээнд 40.3% нь мөгө эд зүйл нэхдэг гэжээ.

Мөн хүүхдэд зориулсан уран зохиол, урлагийн бүтээлийг 15% нь дэмждэггүй гэж хариулсан байхад 18.6% нь дэмждэг, 48% нь хаяа дэмждэг гэж хариулсан байна.

Тус аймаг тулгамдаж байгаа асуудлын нэг нь хүүхдүүдийг сурлага муутайгаар нь ялгаварлан гадуурхах, анги дэвшүүлэхгүй байх зэргээр хөгжих нөхцөл бололцоогүй болгож байгаа явдал ажээ.

Хүүхдүүд хичээл давтах, өөрийгөө боловсруулах, тоглож наадах, сонирхолоо хөгжүүлэх боломжоо алдагдуулан мөнгөтэй болох хүсэлд ихээр хөтлөгдөх болсон байна.

**16. Сэлэнгэ аймаг**

Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдэд чөлөөт цагаа өнгөрөөх байр боломж муу учраас ихэнх цагийн сургууль дээрээ өнжин өнгөрүүлдэг.

**17. Төв аймаг**

Төв аймгийн хэмжээнд сургуульд суралцдаг 18384, сургууль завсардсан 867 хүүхэд бүртгэлтэй байна.

Албан бус боловсролын асуудал аймаг илүү их анхаарал тавьж байгаа бөгөөд 97 хүүхдэд суурь боловсрол олгон, 825 хүүхдийн боловсрол нөхөн олгох сургалтд хамруулжээ.

Бүлгийн ярилцлагын үеэр багагүй хүүхдүүд гадаад хэл, компьютерийн сургалтад хамрагдах хүсэлтэй боловч курс дамжаа байдаггүй, байгаа курс дамжаа нь өдөр үнэтэй байдаг, мөн сургуулиас гадуур соёл хүмүүжлийн ажил зохиогддоггүй, үүнд багш нар идэвхи санаачлага муутай байдаг, анги тахимаа төлбөртэй ашиглуулдаг гэжээ. Үүнээс шалтгаалан сургуулийн хүүхдүүд архи, тамхи хэрэглэх, баар цэнгээний газраар чөлөөт цагаа өнгөрүүлэх болсон тухай дурьджээ.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Түүчлэн хөдөө орон нутагт мэргэжлийн багш, сургуулийн тоног төхөөрөмж дутагдалтай байдгийг онцолсон байна. Алслагдсан сумдын хувьд энэ байдал маш их байдаг ажээ.

**18. Увс аймаг**

Аймгийн хэмжээнд 2002 оны байдлаар 480 сургууль завсардсан хүүхэд байгаа ажээ.

Хамгийн их гардаг зөрчлийн хувьд сургуулийн өмнөх боловсрол, боловсролын асуудлууд Увс аймгийн хувьд жагсаалтын 8, 9-д тус тус бичигджээ.

**19.Ховд аймаг**

Аймгийн хэмжээнд сургууль завсардсан хүүхдийн тоо буурахгүй байна. Цэцэрлэгийн хамралт 26.85%- байна.

20.Хөвсгөл аймаг

2001 оны байдлаар аймгийн хэмжээнд 2-7 насны 20% нь цэцэрлэгт, 8-15 насны хүүхдийн 88.3% нь сургуульд байна.

Аймгийн төвийн сургуулиудын анги дүүргэлт их, ээлжийн коэффицент 2-оос дээш байна. Хөрөнгө санхүүгийн хомсдлоос шалтгаалан дотуур байранд хамрагдвал зохих хүүхдийн 81% нь байранд байна.

аймгийн хэмжээнд 30 орчим багш мэргэжлийн багш дутуу байна.

**21. Хэнтий аймаг**

2001-2002 онд 1165 хүүхдэд суурь боловсрол олгож, сургууль завсардсан 1058 хүүхдээс 696 хүүхэд сургалтад хамрагдаж байгаа нь сургууль завсардсан хүүхдүүдийн 65.7% нь болж байна. БСШУЯ-ны дэмжлэгтэйгээр аймагтаа "Сургууль дундын Интернет мэдээллийн төв"-тэй болоод байна. Мөн ерөнхий боловсролын сургуулийг компьютержүүлэх зорилгоор шат дараалан арга хэмжээ авсны үр дүнд 32 компьютер шинээр нийлүүлээд байна.

Хэнтий аймгийн хувьд боловсролын салбарт байгаа бэрхшээлүүд:

- Галшар суманд дотуур байр нь зориулалтын бус байранд байдаг
- 4 хүүхдийн өрөөнд ор давхарлан 8 хүүхэд байдаг.
- Баян-Овоо сумын сургууль нь 1989 онд ашиглалтад орсон барилга нь чанаргүй баригдсаны улмаас суулт өгч дээд давхрыг ашиглах боломжгүй болсон.
- Биеийн тамрын хичээлийг гадаа ордог
- Сургууль хүйтэн учраас гадуур хувцастайгаа хичээллэдэг
- Монгол хэлний сурах бичиг байдаггүй бөгөөд 6-р ангийн 1 бүлгийн 32 хүүхдийн дунд 5 түүхийн сурах бичиг ашигладаг гэм мэтийг оруулсан байна.

**22. Улаанбаатар хот**

2002 оны эхний хагас жилийн байдлаар нийслэлийн төсвийн 45,5 хувийг боловсролын салбарт зарцуулсан байна.

- Нийслэлийн Засаг даргын сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрт тодорхой зорилтууд тавьсан байна.

2001, 2002 онд жил дараалан сургууль завсардалт 50 хувь буурсны зэрэгцээ олон хүүхэд нь сургуульд сурдаг , орлого багатай өрхийн 1500 гаруй сурагчдад 210 сая төгрөгийн хичээлийн хэрэглэлийг үнэ төлбөргүй олгосон .Хөдөөнөөс шилжин ирээд сургууль завсадаж байсан 400 гаруй хүүхдийг зуны сургалтанд хамруулжээ.

Дүүргийн албан бус боловсролын төвүүд 5-12 сая төгрөгийн төсөвтэй ажиллаж жилд 500 гаруй хүүхдийг ЕБС-д шилжүүлсэн байна.

Япон улсын засгийн газрын буцалтгүй тусламжаар 16 сургуулийн хичээлийн байрны өргөтгөл барих ажил явагдаж байна.

Нийслэлийн 9 дүүргийн 112 хороодод Нийслэлийн Засаг Даргын захирамжаар орон тооны нийгмийн ажилтуудыг ажиллуулж байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Нийслэлийн төсвөөс 2000 онд нийт төсвийн 48,0 хувийг 2001 онд 43,7 хувийг , 2002 онд 42,0 хувийг боловсролын салбарт тус тус зарцуулж 2002 оны байдлаар төрийн өмчийн 93, хувийн 64 сургуульд 166090 хүүхэд суралцаж , 5500 багш ажиллаж байна.

Төрийн өмчийн ЕБС-ийн нэг багшид дунджаар 29 , хувийн хэвшлийн бага сургуулийн нэг багшид 17 сурагч ноогдож байна.

Ерөнхий боловсролын сургуулийн 6 дотуур байранд 747 хүүхэд сууж байна.

Нийслэлийн хэмжээнд мэргэжлийн боловсролын сургууль 84, хүүхдийн цэцэрлэг 154, цэцэрлэгт 30,5 мянган хүүхэд байна.

Улаанбаатар хотод 2000 онд 8-15 насны завсардсан 6096 хүүхдийн 63.3% эрэгтэй хүүхэд байна. Сургуульд хамрагдалтын хувь 12 наснаас эхлэн буурч, 15 насны бүрэн бус дунд боловсрол эзэмших насанд 90.1% хүртлээ буурсны дотор эрэгтэй хүүхдүүдийн эзлэх хувь их байв.

Нийслэлийн Засаг Даргын Тамгын газрын нийгмийн хөгжлийн бодлогын хэлтсээс 2003 онд гаргасан сургууль завсардалтын судалгаанаас үзэхэд 200-2001 онд 960, 2001-2002 онд 840, 2002-2003 онд 602 хүүхэд сургууль завсардсан байна.

**B. Хүүхдийн хамгаалуулах эрхийн хэрэгжилтийн талаар:**

1. Хүүхдийн эрх зєрчигддєг гол газар бол 1-рт гэр бїлийн хїрээнд, 2-р сургуулийн орчинд гэж гарсан нь тун ноцтой їзїїлэлт байна. Тухайлбал гэр бїл салалт, эцэг эх нь ажилгїй байх асуудал хїїхдийн амьдралд сєргєєр нєлєєлж байна. Жишээ нь зарим алтны уурхайтай аймагт хїїхэд нь эцэг эхээ тэжээж хїїхдийнхээ олсон мєнгєєр архи уучихаад, хїїхдийнхээ ирээдїйг бодох нь битгий хэл хїїхдээ зодож суудаг эцэг эх ч байдаг байна.
2. Мєн ядуу амьдрал, амьжиргааны тївшингээс шалтгаалж хїїхдийн эрх зєрчигдєж байна.Тухайлбал: амьдралын байдлаар нь багш нар болон їе тэнгийн хїїхдїїд нь ялгаварлаж хандах, бие биеэ дээрэлхэх, доромжлох, мєнгє татах, байнгын дарамтанд байлгах хувийн нууцад нь халдах їзэгдэл аймаг бїрт байна.
3. Хєдєє орон нутагт хараа хяналтгїй, тэнэмэл хїїхэд харьцангуй бага, зарим аймагт харьцангуй бага гэх болович амьдралын шаардлагаар айлын мал маллаж хєлсєєр нь идэх хоол, ємсєх хувцасаа залгуулдаг, хїнд хїчир хєдєлмєр эрхэлж єчїїхэн бага хєлс авах, зарим тохиолдолд амь насаа алдах зэрэг хїїхдийн эрхийг ноцтойгоор зєрчих явдал нийтлэг байна. Жишээлбэл: Дорнод аймагт 2001 оноос їйл ажиллагаа явуулж ирсэн БНХАУ-ын 100%-ийн хєрєнгє оруулалттай даавууны Шинхуа ХХК-д 17-18 насны охид, хєвгїїдийг эрїїл ахуйн шаардлага хангаагїй, агааржуулалт муутай байранд 25-30 мян.тєг-ийн цалинтай ажиллуулдаг, шєнийн ээлжинд гаргаж, їйлдвэрийн удирдлагын зїгээс дарамт шахалт їзїїлдэг, Баянхонгор аймагт 1 тн ачааг 500 тєг-єєр буулгадаг боловч зарим тохиолдолд хєлсийг нь єгєхгїй байх, Хэнтий аймагт бага насны хїїхдийг морины уралдаанд оролцуулснаар мориноосоо унаж бэртэх, амь насаа алдсан зэрэг тохиолдол байна. Мєн уурхайд ажиллаж байгаа хїїхдїїд нь ямар ч хамгаалалтгїй маш хїнд хєдєлмєр эрхэлж олсон мєнгийг нь эцэг эх авч архи уух, хїїхдээрээ тэжээлгэж байгаа нь нууц биш байна. Тїїнчлэн Тєв аймагт хийсэн судалгаанаас хїїхэд хєдєлмєр эрхлэх явдал нь хэвийн їзэгдэл гэж судалгаанд хамрагдагсдын дийлэнхи олонхи (67.6%) нь їзсэн байна. Хєдєлмєрийн хэлбэр нь: мал маллах, алтны, нїїрсний уурхайд ажиллах, хог тїїх, хїнс барааны захад ачаа зєєх, жижиг худалдаа наймаа хийх, ногоо хураах, гутал зєєх г.м (Хавсралт 1) байна. Їїнээс харахад хїїхдїїд ажиллах байгууллага, хїнтэй гэрээ байгуулах боломжгїйгээс хїїхдийн хєдєлмєрийг їнэлэх хэмжїїр їнэлгээ, тэдний эрхийг хамгаалах тогтолцоо байхгїй байгаа нь харагдаж байна.

4. Байгалийн гамшиг зуд, гангаас болж малгїй болсон айл єрх олширч, аймгийн тєв бараадан хїїхдїїд нь ажил, сургуульгїй учир гэмт хэрэг зєрчилд холбогдох, дэмий тэнэх, орон гэрээсээ дайжих, гадуур хоноглох, бусдын нєлєєнд автагдах, архидах зэрэг сєрєг їзэгдэл гарсаар байна. Тухайлбал: гэмт хэрэгт холбогдсон нийт хїїхдийн 80-90% нь хулгайн хэрэг їйлдсэн байдаг ба 90 орчим хувь нь ядуу, нэн ядуу амьдралтай айлын хїїхдїїд байна. Улаанбаатар, Дархан, Сэлэнгэ аймаг дэд бїтэц сайтай тул галт тэргээр єєр аймаг хотоос орон гэрээсээ дайжсан, хараа хяналтгїй, тэнэмэл хїїхдїїд олноор ирж гэмт хэрэг, эрх зїйн зєрчилд холбогдох, тэр ч байтугай єєрсдєє амиа алдах тохиолдол ч гарсан байна. Жишээ нь:Дорнод аймагт уурын зууханд хонодог хїїхэд тїлэгдсэн тохиолдол гарчээ. Эндээс їзэхэд хїїхдийг гэнэтийн ослын болон бусад даатгалд хамруулах талаар ажил зохиох шаардлага зїй ёсоор гарч ирж байна. Гэмт хэргийн улмаас эрх ашиг нь зєрчигдсєн хїїхэд (Завханд 9, Ємнєговьд 19, Баянхонгорт 1) цєєнгїй байна.
5. Їндэсний хэмжээнд халамж асрамжийн 41 тєвд 1571 (Зарим аймаг ороогїй) гаруй хїїхэд хїмїїжиж байна. Эдгээр хїїхдїїдэд їзїїлсэн нийгмийн їйлчилгээний чанар хїртээмж шаардлагын тївшинд хїрэхгїй байгаа нь (Жишээ нь Хэнтий аймгийн НХЇТ хїмїїжиж байгаа хїїхдїїд ариун цэврийн хангамж маш муу: 14 хоногт 1 удаа 100 Ґ-ийн шампунь єгдєг г.м) зохион байгуулсан ажил, їзїїлсэн тусламж їйлчилгээ, зарцуулсан хєрєнгє мєнгєнєєс тодорхой харагдаж байна. (зєвхєн 1 удаагийн тусламж єгєєд болдог). Гэхдээ зарим нэг талаар амжилттай ажиллаж байгаа тал байна. Жишээлбэл:
    - Орон нутаг бїр гэмт хэрэгт єртєж болзошгїй, хорихоос суллагдсан, хорихоос єєр тєрлийн ял шийтгэлтэй хїїхдїїдийн судалгааг нарийвчлан гаргаж байнгын хяналтанд авч, дахин гэмт хэрэг їйлдэхгїй байх талаар эцэг эх, цагдаа нартай хамран ажиллах талаар анхаардаг болжээ.
    - Мєн хїїхдийн эрх зєрчигдєх їндсэн гол тулгуур асуудлыг судалгаа, янз бїрийн тївшинд хїмїїстэй ярилцсан байдлаас дїгнэлт хийж, тулгадсан асуудлаа гарган ирж холбогдох арга хэмжээг (тєр болон ТББ, ОУБ-уудтай хамтарч) зохион байгуулсан байдал ажиглагдаж байна.
    - Аймгийн шїїхээр гэр бїл цуцлуулсан практикаас харахад хїїхдїїдэд оноож євлїїлсэн хєрєнгє байдаггїй, 1996-2001 онд гэр бїл цуцлалтаас хїїхдїїдийн 90% эхийн асрамжид їлдэж 65% нь тэтгэлэг тогтоолгосон боловч ШШБ албаны ажилтнууд сумдад ажилладаггїйгээс хєдєє амьдардаг эмэгтэйчїїдийн ихэнхи нь тогтоогдсон тэтгэврийг авч чаддагїй гэсэн дїгїэлт Баянхонгор аймагт гарсан байна.

**Г. Хүүхдийн нийгмийн амьдралд оролцох, мэдээлэл хүртэх эрхийн хэрэгжилтийн талаар:**

Хүүхдийн эрхийн төлөв байдлан талаарх судалгаанд оролцогчдын хариултаас дараах зүйлс анхаарал татаж байна. Үүнд:

- ХЭК-ийг хүүхдүүдэд хүрэлцээтэй сурталчлах
- Хүүхдүүд хэвлэл мэдээллийн хэрэгслийг мэдээллийн гол эх сурвалж гэж үздэг
- Хүүхдүүдийн 4/1 нь хүүхдийн олон нийтйин үйл ажиллагаанд огт оролцдоггүй
- Насанд хүрэгчид хүүхдийн санаа бодлыг үл ойшоох нь сэтгэл түгшээх гол зүйл гэж үздэг байна.
- Хүүхдэд зориулсан мэдээллийн цагийг оролцогчдын 52.7 хувь нь бага
- Хүүхдийн оролцоог хүндэтгэн сүүлийн үед тодорхой зорилго тавьсныг дэжмиж байна.
- Нийгмийн ажилтны туслалцаа , хэрэгцээ их нэмэгдэж байгааг мэдрэхийг хүсч байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

- Хүүхдүүдийн хувьд хувийн болон захидал харилцааны нууцаа хамгаалах эрхээ 20,3 %, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ 15,1 %-ийн эрх илүү зөрчигддөг гэж үзсэн байна.

Хөдөө, орон нутагт амьдарч байгаа хүүхдүүд чөлөөт цагаа зүй зохистой өнгөрөөх, мэдээлэл авах боломж хомс бөгөөд жилд хүүхдэд зориулсан теле нэвтрүүлгийн цаг 20, радио нэвтрүүлгийн цаг 14 байгаа жишээ байна. Хүүхдүүд подвалд байрласан тоглоомын газар болон видео кино гаргадаг цэгээр ихэнх цагийг өнгөрөөж байна. Судалгаанд оролцогчдын 58 % нь хүүхэд мэдээллээр дутагддаг,мөн эцэг эхчүүд хүүхдийн бодол санааг үл тоомсорлох, ойлгохгүй сонирхлыг нь хязгаарлах зэргээр хүүхдийн эрхийг зөрчдөг гэжээ.

Хүүхдийн санал бодлыг хүлээн авах, тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд туслах нийгмийн үйлчилгээ хомс байна. Сургуулиудын удирдлага хүүхдүүдийн санал, санаачилгын сонсоод эрх бүхий байгууллага, этгээдийн зөвшөөрөл авахыг шаарддаг.

Аймгийн Шүүхээр шийдвэрлэдэг гэр бүл цуцлалтын практикаас харахад хүүхдүүдэд оноосон, өвлүүлсэн хөрөнгө байдаггүй. Энэ нь хүүхдийн тэтгэврийн асуудал, өмчийн маргаан зэргийг шийдэхэд хүндрэл учруулдаг юм. 1996-2001 онд гэр бүл цуцлалтаас хүүхдүүдийн 90 % нь эхийн асрамжинд үлдэж, 65 % нь тэтгэлэг тогтоолгосон боловч ШШБ албаны ажилтнууд сумдад байхгүйгээс эмэгтэйчүүдийн ихэнх хувь хүүхдийн тэтгэвэрээ авч чадахгүй байна.

Хүүхэд нийгмийн амьдралд оролцох боломж дунд зэрэг гэж олонхи буюу 64,9 % нь, мөн хүүхэд ажил хөдөлмөр эрхлэх нь хэвийн явдал гэж дийлэнхи буюу 67,6 % нь хариулсан байна.

Хөдөө орон нутаг, нийслэлд хүүхдүүдийн дунд доорх байгууллага илүү үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- “Шинэ зууны элч” хүүхдийн зөвлөл
- Скаутын холбоо
- Өсвөрийн Улаанзагалмай
- Өсвөрийн сэргийлэгчид
- Дэлхийн Зөн байгууллагын дэргэдэх Хүүхдийн өөрийн удирдлагатай зөвлөл
- Миний паспорт аяны хүрээнд зохион байгуулагдсан сумдын болон ЕБС-ийн бүлгүүд байдаг.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС

ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ ҮНДЭСНИЙ ГАЗАР

МОНГОЛЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТӨВ

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийг насны хувьд авч үзвэл :

- 14-өөс доош насны хүүхэд 103 буюу 35,4%
- 15-16 насны хүүхэд 132 буюу 45.0%
- 17-18 насны хүүхэд 55 буюу 18.9 хувь байна.




Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн ам бүлийн байдлыг авч үзвэл :

1-3 ам бүлтэй – 37 буюу 12.7%, 4-6 ам бүлтэй – 213 буюу 73.2%, 7-дээш ам бүлтэй 41 буюу 14.0% байна.

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн эцэг эхийн боловсролыг нарийвчлан гаргаж үзвэл:

Эцгийн боловсрол:

- Дээд боловсролтой 139 буюу 47.8%
- Тусгай дунд боловсролтой 38 буюу 13.1%
- Бүрэн дунд боловсролтой 75 буюу 25.8%
- Бүрэн бус дунд боловсролтой 20 буюу 6.9%
- Бага боловсролтой 4 буюу 1.4%
- Боловсролгүй 2 буюу .7%
- Бөглөгдөөгүй /эцэггүй/ гэж 12 хүүхэд буюу судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 4.1% нь хариулсан байна.

Эхийн боловсрол:

- Дээд боловсролтой 129 буюу 44.3%
- Тусгай дунд боловсролтой 34 буюу 11.7%
- Бүрэн дунд боловсролтой 92 буюу 31.6%
- Бүрэн бус дунд боловсролтой 27 буюу 9.3%
- Бага боловсролтой 4 буюу 1.4%
- Боловсролгүй гэж 4 буюу 1.4% нь хариулжээ.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

“Хүүхдийн эрхийг хамгаалах тухай Монгол улсын хуулийн хэрэгжилтийн үнэлгээ, хүүхдийн эрхийн төлөв байдал” судалгааны мөрөөр хүүхдээс авсан санал асуулгын тайлан.

Судалгаа авах хэрэгцээ: Монгол улсад 2000 оны байдлаар хүн амын 46.6%-ийг18 хүртэлх насны хүүхэд эзэлж байна. Манай улс 1989 онд “Хүүхдийн эрхийг хамгаалах тухай” НҮБ-ын конвенцид нэгдэж орсон 5 дахь орон болж, 1996 онд “Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль”-ийг батлан хэрэгжүүлж эхэлснээс хойш 7 жил боллоо. Хүүхдийн эрх ашигтай холбоотой нийгмийн харилцааг үндэсний 60 шахам хуулиар зохицуулж байгаа ч нийгмийн амьдралын бүх хүрээнд хүүхдийн язгуур эрх ашгийг хамгаалах, тэднийг үл ялгаварлах, эсэн мэнд амьдрах ба хөгжих, үзэл бодлыг нь хүндэтгэх үндсэн эрхүүд зөрчигдөж, хүүхэд хүнд хөдөлмөр эрхлэх, сургууль завсардах, улмаар гэр орноосоо дайжих гэмт хэрэгт өртсөөр байна. Иймд хүүхдийн эрхийн зөрчлийн шалтгааныг илрүүлэхэд олон нийтийн санаа бодол сонсох тэр дундаа хүүхдийн үгийг сонсох, санаа бодлыг нь судалж, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагаагаа тодорхойлох шаардлагатай байгааг харгалзан 2003 оны 02 сарын 15-наас 03 сарын 25-ныг хүртэлх хугацаанд Хүний Эрхийн Үндэсний комисс, Монголын Хүүхдийн эрхийн Төв, Хүүхэд залуучуудын хөгжлийн газар, УБИС-ийн Түүх нийгмийн тэнхимийн судалаач багш Түмэндэлгэр нарын бүрэлдэхүүнтэйгээр судалгааг нийслэлийн хүрээнд явууллаа.

Судалгааны зорилго: Хүүхдийн эрхийг хамгаалах тухай Монгол улсын хуулийн хэрэгжилтэд үнэлгээ өгч, хүүхдийн эрхийн төлөв байдлыг тодорхойлох.

Судалгааны зорилт:

- Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг судлах
- Хүүхдийн эрхийн төлөв байдал ямар байгааг асуулгын аргаар судлах
- Хүүхдийн эрхийн зөрчлийн үндсэн шалтгаан, түүнээс сэргийлэх арга замын талаар хүүхдийн санаа бодлыг судлах
- Хүүхдийн эрх нийгмийн аль хэсэгт, ямар шалтгаанаар зөрчигдөж байгааг нарийвчлан гаргах
- Цаашид хүүхдийн эрх ашгийг хамгаалах талаар хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлийг гаргах

Судалгааны хамрагдсан хүрээ:

Судалгаанд нийслэлийн ЕБС-иудын нийт 290 хүүхэд хамрагдсан бөгөөд хамрагдсан хүүхдүүдийн 143 буюу 49,1% нь эрэгтэй хүүхэд,147 буюу 50.5% нь эмэгтэй хүүхэд байгаа нь судалгааны дүгнэлтийг гаргахад эрэгтэй хүүхдэд тулгамдсан асуудал, эмэгтэй хүүхдүүдэд тулгарсан бэрхшээл, түүнд нөлөөлсөн асуудлыг гаргахад бодит дүгнэлт өгөхөд нөлөөлсөн гэж бодож байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Мөн судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн эцэг эхийнх нь эдийн засгийн идэвхийн байдлыг авч үзвэл: 110 буюу 37.8% төсвийн байгууллагад ажилладаг, 57 буюу 19.6% нь хувийн секторт ажилладаг, 25 буюу 8.6% нь төрийн бус байгууллагад, 64 буюу 22.0% нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг, 14 буюу 4.8% нь тэтэгэвэр тэтгэмж авдаг, 19 буюу 6.5% нь ажилгүй, 1 буюу .3% нь бусад дурьдаагүй газарт ажилладаг гэсэн хариултыг өгсөн бөгөөд эдгээр судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн гэр бүлийнх нь өрхийн гол эх үүсвэрийг авч үзвэл: 178 буюу 61.2% нь цалин, 8 буюу 2.7% нь тэтэгэвэр, 4 буюу 1.4% нь тэтгэмж, 80 буюу 27.5%хувиараа хөдөлмөр эрхэлж, 13 буюу 4.5% нь жижиг худалдаа, наймаа, 2 буюу 7% нь буцалтгүй тусламж, 5 буюу 1.7% нь бусад өөр төрлөөр гэсэн хариултыг өгчээ.. Асуултанд 290 хүүхэд бүгд хариулсан.

Сарын орлогын дундаж хэмжээ нь :

- 1000000-с дээш 5 1.7%
- 500-999 мянга 9 3.1%
- 150-499 мянга 55 18.9%
- 50-149 мянга 178 61.2%
- 49-хүртэл 43 14.8%

Амьдардаг байр сууцыг төрлөөр нь авч үзвэл:

- Орон сууцад амьдардаг 146 хүүхэд буюу 50.2%
- Галладаг сууц 73 25.1%
- Гэрт 48 16.5%
- Нийтийн байранд амьдардаг 4 1.4%
- Халамжийн төвд 17 5.8%
- Бусад 2 .7%

Бүгд 290 хүүхэд буюу 99.7% асуултанд хариулсан.

## Хүүхдийн эрхийн төлөв байдлын талаар хүүхдүүдээс авсан асуулгын дүн :

**Хүүхдийн эрхийн тухай конвенци хуулийн талаар мэдэх үү?** гэсэн асуултанд судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 75 буюу 25.8% нь мэднэ, 147 хүүхэд буюу 50.5% нь муухан мэднэ, 32 хүүхэд буюу 11.0% нь нэрийг нь дуулснаас цаашгүй гэж хариулсан бөгөөд, мэдэхгүй гэсэн хариултыг 36 хүүхэд буюу судалгаанд оролцсон хүүхдүүдийн 12.4% нь хариулсан байна. Энэ асуултанд нийт 290 хүүхэд 99.7% хариулсан.

Танд хүүхдийн эрхийн тухай хичээл заадаг уу? гэсэн асуултанд

- Заадаг гэж хариулсан 153 хүүхэд 52.6%
- Маш бага заадаг 64 буюу 22.0%
- Заадаггүй 56 буюу 19.2%
- Мэдэхгүй гэсэн хариултыг 17 хүүхэд буюу 5.8% нь өгчээ..

Та эрхийнхээ тухай хаанаас олж мэддэг вэ? Гэсэн асуултанд судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 31 буюу 9.6% нь сонин хэвлэлээс, 80 хүүхэд буюу 27.5%нь телевизээс, 157 буюу 54.0% нь багш, нийгмийн ажилтан нараас, 12 хүүхэд буюу 4.1% нь эцэг эх, гэр бүлийнхнээсээ сонссон гэжээ. Мөн өөр дурьдагдаагүй газраас сонссон гэсэн хариултыг 10 хүүхэд буюу 3.4%нь өгсөн байна.

2. Багш, ажилтнууд сурагчдад ялгавартай ханддаг уу? Гэсэн асуултанд

- Тийм 164 буюу 56.4%
- Үгүй гэж 126 буюу 43.3% нь хариулсан бөгөөд хэрэв ялгаварлах

хандлага байдаг бол ямар байдлаар ялгаварладаг вэ?гэсэн нарийвчилсан асуултанд

| | | |
|---|---|---|
| Эцэг эхийн албан тушаалын байдлаар | 29 | 9.6% |
| Зүс царайгаар | 39 | 13.4% |
| Хүйсээр | 11 | 3.8% |
| Амьдардаг орчноор | 15 | 5.2% |
| Өмссөн хувцасаар | 55 | 18.9% |

- Хөрөнгө чинээний байдлаар ялгаварладаг гэж 84 хүүхэд хариулсан бөгөөд энэ нь бусад хариултын хамгийн их хувь буюу 28.9%-ийг эзэлж байна.
- Мөн өөр хэлбэрээр ялгаварладаг гэсэн хариултыг 14 хүүхэд буюу 4.8% нь хариулсан байна. Дээрх хариултуудыг графикаар харьцуулж үзвэл :




UIH.MN СУДАЛГААНЫ САН

Таныг сурч боловсроход тань ямар нэгэн бэрхшээл байдаг уу? гэж асуухад тийм байдаг гэсэн 110 хүүхэд буюу 37.6%, үгүй байдаггүй гэсэн хариултыг 180 хүүхэд буюу 61.4% нь өгсөн байна.

Таныг сурч боловсроход мөнгө, эд зүйл шаарддаг уу? Гэсэн асуултанд

Байнга шаарддаг гэж 67 хүүхэд буюу 23.0%, хааяа шаарддаг гэсэн 170 хүүхэд буюу 58.4%нь хариулсан байхад үгүй шаарддаггүй гэж 53 хүүхэд буюу 18.2% нь хариулжээ.

Хүүхдийг сурч, хөгжиж, амьдрахад ямар зүйлс хэр хэмжээгээр дутагдаж, гачигдаж байгааг тодруулж асуухад :

Хоол хүнсээр гэж 10 хүүхэд буюу судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 3.4% нь , өмсөх зүүхээр 15 хүүхэд 5.2%,орон сууцаар 7 хүүхэд буюу 2.4%нь, сургалтын техник тоног төхөөрөмжөөр 46 хүүхэд буюу 15.8%, сурах бичиг ном материалаар гэж 39 хүүхэд буюу 13.4% нь, чөлөөт цагаа өнгөрөөх нөхцөл боломжоор 30хүүхэд буюу 10.3%, үзэл бодлоо илэрхийлэх боломжоор дутагддаг гэж 30 хүүхэд буюу 10.3% нь, мэдээллээр 39 хүүхэд 13.4% нь, нас биендээ тохирсон тоглох тоглоомоор дутагддаг гэж 8 хүүхэд буюу 2.7% нь, бусад зүйлээр дутагддаг гэсэн хариултыг 32 хүүхэд буюу 11.0% нь өгсөн байна. Мөн энэ асуултанд 11.7% нь буюу 34 хүүхэд хариулсангүй. Эдгээр хүүхдүүдэд дутагдаж гачигдаж буй зүйлийг графикаар үзүүлбэл :




Дээрх графикаас харахад хүүхэд сургалтын техник тоног төхөөрөмжөөр дутагдаж байна гэж хамгийн их хувь гарсныг зохих мэргэжлийн хүмүүс анхааралдаа авах нь зүйтэй болов уу. Мөн энд дурьдаж хэлэхэд хүүхдүүд чөлөөт цагаа өнгөрөөх боломж муутай, гэртээ найзуудтайгаа уулзъя гэхээр ээж аав нь загнадаг, сургууль дээр цугларна гэхээр жижүүр хөөдөг, баарапд орохоор заавал архи юм уу пиво ав гэдэг, Мөн баарапд суухаар янз бүрийн хүмүүс ирдэг ингээд л ихэнх хүүхдүүд буруу замруугаа орох үүд тавигддаг, телевизээр гарч буй японы, америкийн кино үзээд ээж аав нь мөнгө өгөхгүй бол бие үнэлж мөнгө олж болох юм байна гэсэн бодол төрдөг гэсэн 10-р ангийн хэсэг охидуудын яриаг толилуулах нь зүйтэй болов уу

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

3. Таны эрхийг хэн нь илүү зөрчдөг вэ? гэсэн асуултанд хариулсан 290 хүүхдээс **Үе тэнгийхэн** гэж 138 хүүхэд буюу 47.4%хариулсан нь хамгийн их оноог эзэлж байна. Бусад хувилбаруудыг авч үзвэл :

- Эцэг эх 26 8.9%
- Асран хамгаалагчид 20 6.9%
- Багш нар 57 19.6%
- Хуулийн байгууллагын ажилтнууд 23 7.9%
- Бусад хүмүүс 93 32.0%

Судалгааны явцад хүүхдүүдтэй ярилцаж байхад хүүхдүүд эрх үүргийнхээ талаар мэддэг болович яаж эрхээ эдлэх вэ гэдгийг төдийлөн сайн ойлгоогүй нь харагдаж байсан бөгөөд Багш харилцааны доголдолтой, хичээл орж байна гэж ихэнх цагийг хэрүүл хийж өнгөрөөдөг, эсвэл номны тэд дүгээр хуудаснаас дасгал ажил гэж үүрэг өгчихөөд гараад явцихдаг, мөн эцэг эхчүүд хүүхдээ сайн хүн болгож хүмүүжүүлж байна гээд хэт их үглэж, цагдаж хоридог талаар хүүхдүүд гомдоллон ярьж байсныг энд дурдах нь зүйтэй болов уу. / Нийслэлийн 33-р сургуулийн хэсэг сурагчидтай хийсэн ярилцлаганаас .../

Хүүхдийн эрх зөрчигдөж байгаа эсэх. Чухам ямар эрх зөрчигдөж байгааг судлахад:

Сурч боловсрох эрх зөчигдөж байна гэж 9 хүүхэд буюу 3.1%, Эрүүл мэндээ хамгаалуулах эрх зөрчигддөг гэсэн 29 хүүхэд 10.0%, Аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигддөг гэж 66 хүүхэд буюу 22.7% нь, Хувийн болон захидал харилцааны нууцаа хамгаалах гэж 59 хүүхэд 20.3%, Чөлөөтэй бодож сэтгэх, мэдээлэл хайх 42 хүүхэд буюу 14.4%, Хүчирхийллээс ангид байх эрх зөрчигдөж байна гэж 32 хүүхэд буюу 11.0%, Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх зөрчигддөг гэсэн 44 хүүхэд буюу 15.1% нь, Эвлэлдэн нэгдэх, оролцооны эрх зүөрчигдөж байна гэсэн хариултыг 33 хүүхэд буюу 11.3% нь, бусад дээр дурьдагдаагүй асуудал зөрчигдөж байна гэж 3 хүүхэд буюу 1.0% нь хариулжээ.




Дээрх графикаас харахад аюулгүй орчинд амьдрах эрх буюу **хүүхдийн хамгаалуулах эрх** илүүтэй зөрчигдөж байна.

Хүүхдийн төлөө үйл ажиллагаагаа явуулдаг олон төрийн болон төрийн бус байгууллагууд байдаг. Одоогоор Улаанбаатар хотод хүүхдийн төлөө үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус нийлээд 163 гаруй байгууллагууд ажиллаж байна. Харин хүүхдээс хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагуудыг мэддэг үү? Гэсэн асуултанд

- Мэднэ гэсэн хариултыг 110 хүүхэд буюу 37.8%
- Мэдэхгүй гэсэн хариултыг 177 хүүхэд буюу 62.2% нь өгчээ.




Мэддэг гэж хариулснаас ихэнх нь UNECEF, Хүүхдийн төлөө Үндэсний хороо, Монголын хүүхдийн эрхийн төв, Скаутын холбоо зэрэг хүүхдийн байгууллагуудыг нэрлэсэн байв.

Хүүхдийн нийгэмд оролцох идэвхи оролцоог судлах зорилгоор **Та хүүхдийн олон нийтийн байгууллагын үйл ажиллагаанд оролцдог уу?** Гэсэн асуултанд

| | | |
|---|---|---|
| Оролцдог | 38 | 13.1% |
| Хааяа | 85 | 29.2% |
| Үгүй | 167 | 57.3% |




UIH.MN
СУДАЛГААНЫ САН

“Таны хүүхэд дор дурьдсан зүйлсээс гачигдаж дутагддаг уу?” гэсэн асуултын ихэнх хувь буюу 36.2%--ийг хүүхэд чөлөөт цагаа өнгөрөөх нөхцөл боломжоор дутагдаж байна гэж хариулсан нь эцэг эхчүүд хүүхдийнхээ хөгжих, нийгмийн амьдралд оролцох эрхийг хангах талаар нэлээд их санаа зовж явдагийг харуулж байна.

“Телевиз радио зэрэг мэдээллийн хэрэгслийн хүүхдэд зориулсан нэвтрүүлгийн цаг ямар байна гэж та үздэг вэ?” гэсэн асуултанд 51.0% нь боломжийн гэж хариулж байгаа нь хүүхдүүд чөлөөт цагаа телевиз, радио сонсож өнгөрөөдөг юм байна дүгнэж болохоор байна.

Хүүхдийн ажил, хөдөлмөрийн тухай олон нийтийн ойлголт ямар байдаг талаар судлах зорилготой асуулганд нийт судалгаанд оролцогчдын 75.8% нь зөв хариулт буюу хүүхдийн ажил нь хэвийн нас, бие бялдарт нь муугаар нөлөөлдөггүй, өөрт нь тохирсон байх хэрэгтэй гэж хариулсан байгаа нь энэ асуудлаарх олон нийтийн ойлголт сайн байна гэж дүгнэхээр байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

***Насанд хүрэгчдийн дунд явуулсан асуулгын товчоон***

| д/д | Асуулга | Тоо | | | | | | | | | | | | | Дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Өмнөговь | Дорноговь | Төв | Булган | Дундговь | Увс | Дархан-уу | Баянөлгий | Сүхбаатар | Архангай | Завхан | Дорнод | Ховд | |
| 1 | ***Хүүхэд гэж хэн бэ?*** | | | | | | | | | | | | | | |
| | 16 насанд хүрээгүй хүн | 21 | 33 | 44 | 49 | 89 | 44 | 38 | 98 | 106 | 48 | 65 | 201 | 43 | 879 |
| | аав ээжийнхээ асрамжид байгаа | 16 | 45 | 10 | 21 | 42 | 25 | 29 | 30 | 90 | 25 | 41 | 137 | 37 | 549 |
| | 18 насанд хүрээгүй хүн | 39 | 19 | 20 | 46 | | 15 | 24 | 60 | 49 | 24 | 10 | 115 | 28 | 449 |
| | Мэдэхгүй | | 2 | | | | 1 | 2 | 0 | | 3 | | 7 | 2 | 17 |
| 2 | ***Та хүүхдийн эрхийг хамгаалах конвенци, хуулийн талаар хэр мэдлэгтэй вэ?*** | | | | | | | | | | | | | | |
| | Мэднэ | 28 | 17 | 17 | 37 | 24 | 21 | 20 | 55 | 51 | 15 | 22 | 98 | 31 | 436 |
| | Дунд зэрэг | 30 | 45 | 28 | 43 | 57 | 21 | 43 | 83 | 126 | 62 | 54 | 190 | 49 | 831 |
| | Сонссон | 15 | 29 | 23 | 27 | 29 | 18 | 21 | 30 | 57 | 19 | 25 | 127 | 28 | 448 |
| | Мэдэхгүй | 4 | 8 | 6 | 5 | 21 | 4 | 9 | 20 | 8 | 4 | 15 | 37 | 4 | 145 |
| 3 | ***Та хүүхдийн эрх зөрчигддөг гэж үздэг үү?*** | | | | | | | | | | | | | | |
| | Зөрчигддөг | 44 | 73 | 51 | 63 | 97 | 53 | 72 | 83 | 145 | 60 | 75 | 295 | 75 | 1186 |
| | Бага зэрэг | 29 | 21 | 20 | 51 | 31 | 22 | 15 | 86 | 85 | 33 | 38 | 139 | 31 | 601 |
| | Зөрчигддөггүй | 4 | 5 | 3 | 1 | 3 | 7 | 6 | 20 | 15 | 7 | 5 | 13 | 2 | 91 |
| 4 | ***Хүүхдийн эрхийн зөрчил аль салбарт илүү байна вэ?*** | | | | | | | | | | | | | | |
| | Боловсрол | 29 | 36 | 27 | 52 | 96 | 38 | 51 | 33 | 87 | 50 | 52 | 189 | 57 | 797 |
| | Эрүүл мэнд | 11 | 18 | 9 | 18 | 42 | 23 | 18 | 33 | 6 | 29 | 20 | 48 | 16 | 291 |
| | Нийгмийн халамж | 30 | 22 | 17 | 28 | 53 | 22 | 30 | 49 | 77 | 38 | 38 | 111 | 45 | 560 |
| | Гэр бүлийн хүрээнд | 61 | 62 | 47 | 31 | 111 | 50 | 81 | 51 | 227 | 75 | 68 | 244 | 73 | 1181 |
| | Хууль хяналтын байгууллагын | 17 | 13 | 8 | | 31 | 11 | 22 | 31 | 8 | 18 | 10 | 62 | 18 | 248 |
| 5 | ***Сургуулийн өмнөх насны болон ЕБС-ийн хүрээнд доорх зөрчлүүд байдаг уу?*** | | | | | | | | | | | | | | |
| | Мөнгө эд зүйл шаардах | 47 | 54 | 55 | 77 | 97 | 47 | 72 | 71 | 121 | 41 | 74 | 278 | 61 | 1095 |
| | Ямар нэг байдлаар хүүхдэд ялгавартай хандах | 41 | 69 | 33 | 53 | 93 | 53 | 72 | 84 | 157 | 70 | 76 | 260 | 69 | 1130 |
| | Дарамтлах | 11 | 14 | 13 | 26 | 83 | 22 | 33 | 21 | 23 | 24 | 11 | 53 | 24 | 358 |
| | Хүч хэрэглэх | 7 | 10 | 5 | 1 | 51 | 5 | 21 | 13 | 14 | 6 | 6 | 15 | 16 | 169 |
| 6 | ***Хүүхдийн эсрэг хүчирхийлэл аль хэр байдаг вэ?*** | | | | | | | | | | | | | | |
| | Их | 14 | 27 | 18 | 56 | 78 | 27 | 42 | 23 | 50 | 13 | 22 | 148 | 22 | 539 |
| | Бага зэрэг | 57 | 66 | 44 | 86 | 52 | 40 | 46 | 126 | 160 | 76 | 69 | 247 | 73 | 1142 |
| | Байхгүй | 5 | 6 | 11 | 5 | 1 | 10 | 5 | 40 | 28 | 7 | 20 | 24 | 16 | 178 |
| 7 | ***Хүүхдийн эсрэг хүчирхийлэл доорх салбаруудад гардаг уу?*** | | | | | | | | | | | | | | |
| | Боловсролын салбарт | 28 | 32 | 18 | 47 | 104 | 29 | 48 | 26 | 61 | 28 | 33 | 149 | 28 | 631 |
| | Гэр бүлийн хүрээнд | 42 | 59 | 45 | 83 | 121 | 44 | 72 | 59 | 156 | 64 | 61 | 242 | 63 | 1110 |
| | Хууль хяналтын байгууллагын | 12 | 13 | 8 | 21 | 19 | 12 | 24 | 17 | 24 | 23 | 10 | 78 | 10 | 271 |
| | Гудамж талбайд | 34 | 42 | 29 | 63 | 75 | 34 | 63 | 87 | 126 | 49 | 66 | 204 | 71 | 943 |
| 8 | ***Таны хүүхэд доорх зүйлээр дутагддаг уу*** | | | | | | | | | | | | | | |
| | Хоол хүнсээр | 10 | 22 | 15 | 25 | 43 | 9 | 11 | 14 | 13 | 9 | 12 | 86 | 8 | 277 |
| | Хувцас хэрэглэлээр | 15 | 30 | 14 | 26 | 68 | 12 | 10 | 24 | 7 | 21 | 28 | 116 | 8 | 379 |
| | Орон байраар | 9 | 13 | 3 | 7 | 19 | 5 | 21 | 3 | 130 | 10 | 9 | 55 | 83 | 367 |
| | Мэдээллээр | 34 | 54 | 32 | 82 | 102 | 40 | 55 | 72 | 35 | 66 | 66 | 169 | 59 | 866 |
| | Эрүүл мэндийн үйлчилгээгээр | 26 | 16 | 21 | 21 | 38 | 29 | 29 | 40 | 56 | 38 | 39 | 114 | 24 | 491 |
| | Сурах боломжоор | 19 | 14 | 14 | 46 | 76 | 19 | 29 | 35 | | 19 | 30 | 156 | 22 | 479 |
| 9 | ***Хүүхдэд төрөөс үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээ ямар байна гэж та үздэг вэ?*** | | | | | | | | | | | | | | |
| | Боломжийн | 15 | 39 | 21 | 32 | 40 | 22 | 25 | 50 | 74 | 16 | 24 | 126 | 41 | 526 |
| | Учир дутагдалтай | 47 | 44 | 30 | 65 | 57 | 40 | 38 | 55 | 132 | 59 | 62 | 194 | 37 | 861 |
| | Хангалтгүй | 14 | 16 | 20 | 12 | 34 | 16 | 30 | 83 | 39 | 21 | 37 | 132 | 31 | 486 |
| 10 | ***Хүүхэд амралт чөлөөт цагаа өнгөрөөх нөхцөл боломж ямар байна вэ?*** | | | | | | | | | | | | | | |
| | Сайн | 11 | 7 | 2 | 13 | 10 | 14 | 6 | 33 | 20 | 3 | 2 | 24 | 22 | 166 |
| | Дунд | 46 | 62 | 46 | 49 | 56 | 36 | 32 | 88 | 132 | 60 | 73 | 275 | 59 | 1014 |
| | Муу | 19 | 30 | 18 | 41 | 65 | 29 | 55 | 68 | 91 | 36 | 39 | 155 | 30 | 676 |

***Насанд хүрэгчдийн дунд явуулсан асуулгын товчоон***

| д/д | Асуулга | Тоо | | | | | | | | | | | | | Дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Өмнөговь | Дорноговь | Төв | Булган | Дундговь | Увс | Дархан-уул | Баянөлгий | Сүхбаатар | Архангай | Завхан | Дорнод | Ховд | |
| | ***Хүүхдэд зориулсан урлаг, утга зохиол, уран сайхны бүтээлүүдийг төрөөс хэрхэн дэмждэг вэ?*** | | | | | | | | | | | | | | |
| 11 | Дэмждэг | 24 | 26 | 31 | 29 | 21 | 24 | 26 | 58 | 56 | 26 | 34 | 87 | 39 | 481 |
| | Заримдаа дэмждэг | 33 | 62 | 27 | 51 | 66 | 32 | 18 | 88 | 144 | 53 | 57 | 234 | 61 | 926 |
| | Дэмждэггүй | 19 | 11 | 11 | 20 | 44 | 22 | 49 | 43 | 45 | 18 | 29 | 118 | 10 | 439 |
| | ***Телевиз радио зэрэг мэдээллийн хэрэгслээр хүүхдэд зориулсан нэвтрүүлгийн цаг ямар байна гэж та үздэг вэ?*** | | | | | | | | | | | | | | |
| 12 | Боломжийн | 29 | 39 | 42 | 59 | 35 | 32 | 44 | 66 | 121 | 39 | 36 | 227 | 29 | 798 |
| | Бага байна | 47 | 60 | 32 | 61 | 96 | 51 | 49 | 123 | 124 | 54 | 74 | 230 | 81 | 1082 |
| | ***Та хүүхдийн эрхийн талаархи мэдээллийг хаанаас авдаг вэ?*** | | | | | | | | | | | | | | |
| 13 | Сонин хэвлэлээс | 52 | 57 | 33 | 72 | 71 | 44 | 49 | 80 | 131 | 64 | 66 | 203 | 75 | 997 |
| | Телевиз радиогоос | 41 | 77 | 53 | 91 | 90 | 54 | 76 | 53 | 164 | 79 | 80 | 297 | 63 | 1218 |
| | насанд хүрэгчдээс | 5 | 10 | 4 | 4 | 7 | 10 | 9 | 16 | | 1 | 4 | 29 | 4 | 103 |
| | Найз нөхдөөсөө | 19 | 4 | 3 | 4 | 13 | 8 | 18 | 4 | | 6 | 5 | 45 | 12 | 140 |
| | Олж мэдэх боломжгүй | 9 | 10 | 7 | 16 | 85 | 5 | 5 | 45 | 21 | 7 | 5 | 57 | 10 | 282 |
| | ***Гэмт хэрэг анх үйлдсэн хүүхдэд ямар шийтгэл оноохыг зөв гэж үздэг вэ?*** | | | | | | | | | | | | | | |
| 14 | Хорих | | 1 | 5 | 4 | 4 | 3 | 1 | 0 | 17 | | 1 | 10 | 20 | 66 |
| | Хорих ял оноож, эдлэлтийг нь болзолтойгоор түдгэлзүүлэх | 4 | 14 | 17 | 17 | 24 | 13 | 15 | 18 | 84 | 15 | 11 | 122 | 10 | 363 |
| | Хорихоос өөр төрлийн | 71 | 84 | 50 | 95 | 103 | 63 | 77 | 171 | 60 | 82 | 88 | 316 | 80 | 1341 |
| | ***Хүүхэд нийгмийн амьдралд оролцох боломж ямар байна вэ?*** | | | | | | | | | | | | | | 0 |
| 15 | Сайн | 7 | 3 | 7 | 21 | 8 | | 62 | 28 | 17 | 2 | 11 | 41 | 16 | 222 |
| | Дунд | 50 | 75 | 48 | 68 | 81 | | 10 | 106 | 164 | 53 | 70 | 312 | 77 | 1113 |
| | Муу | 12 | 21 | 18 | 27 | 42 | | 21 | 55 | 60 | 34 | 22 | 91 | 18 | 421 |
| | ***Хүүхдийн ажил хөдөлмөрийг та юу гэж үздэг вэ?*** | | | | | | | | | | | | | | |
| 16 | Хүүхдийн ажил, хөдөлмөр 2 ялгаагүй | 2 | 36 | 4 | 1 | 6 | 3 | 2 | 8 | | 1 | 2 | 46 | 6 | 116 |
| | Хүүхдийн ажил нь хэвийн нас, бие бялдарт нь тохирсон байх | 41 | 49 | 54 | 83 | 105 | 59 | 71 | 146 | 216 | 84 | 78 | 326 | 88 | 1400 |
| | Хүүхдийн хөдөлмөр нь хүүхдийн нас, бие бялдарт нь муугаар нөлөөлөхгүй | 24 | 14 | 16 | 32 | 20 | 18 | 20 | 35 | 26 | 7 | 21 | 75 | 16 | 324 |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## 1.1. Хүүхдийн эрхийн төлөв байдал

2000 оны улсын хүн амын нэгдсэн тооллогоор манай улсын хүн ам 2375,5 мянгад хүрч, дундаж өсөлт 1,4 хувь байсан нь сүүлийн 50 жилийн доторхи хамгийн бага үзүүлэлт болжээ.

Нийт хүн амын доторхи хүүхдийн эзлэх хувийн жин өндөр хэвээр, 46,6 хувийг 18 хүртэлх насныхан, 12,1 хувийг 19-24 насныхан эзэлж байна.

Монгол Улс 1990 онд НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцид нэгдэн орж, конвенцийн үзэл санаанд нийцүүлэн үндэсний хууль тогтоомжоо боловсронгуй болгох ажлыг шат дараатай хийж, 1996 онд Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийг батлан гаргаж, энэ хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих, хүүхдийн эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий Хүүхдийн төлөө үндэсний газар, аймгуудад хүүхдийн төлөө төв байгуулж, 2002 онд Монгол Улсын Засгийн газраас “Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр”-ийг батлан гаргаж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж эхэлсэн.

Түүнчлэн Монгол Улс хүүхдийн хөдөлмөрийн талаархи Олон улсын хөдөлмөрийн байгууллагын /ОУХБ/ холбогдох конвенциудад нэгдэн орж, хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх, хүүхдийн эрхийг хамгаалахад чиглэгдсэн зорилт, арга хэмжээг дотоодын хууль тогтоомжид тусгаж, хэрэгжүүлэхийн төлөө ажилласан байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Олон улсын болон гадаадын цөөнгүй байгууллага, иргэд хүүхдийн эрхийг хамгаалахтай холбоотой багагүй тооны төсөл хөтөлбөр хэрэгжүүлж, дотоодын 70 орчим төрийн бус байгууллага хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр дагнасан үйл ажиллагаа явуулдаг байна.

Монголын төр, засгаас хүүхдийн эрхийг хамгаалах, хөгжүүлэх чиглэлээр олон чухал арга хэмжээ авч байгаа хэдий ч, нийгэм, эдийн засгийн чадавхи, ажилгүйдэл, ядууралтай холбоотойгоор хүүхдийн эрх зөрчигдөж, олон асуудлууд анхраарал татсаар байна.

ХЭҮК-оос энэ оны эхний улиралд хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт, хүүхдийн эрхийн асуудлаар хийсэн судалгаа, ОУХБ-ын болон ТББ-уудаас хийсэн судалгаануудаас үзэхэд хүүхдийн эрхийн тулгамдсан дараах асуудлууд анхаарал татаж байна.

**1.1.1. Хүүхдийн амьдрах эрх.** Монгол Улсын Засгийн газар, ДЭМБ, НҮБ-ын Хүүхдийн сан, Хүн амын сан болон хандивлагч, түншлэгч орнуудын олон талын дэмжлэгтэйгээр эх, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, өвчлөл, эндэгдлийг бууруулах, эцэг, эхийн эрүүл мэндийн тусламж хайх мэдлэг, чадварыг дээшлүүлэх хүүхдийг дархлаажуулах, хөхүүлэх, хоол хүнсний хангамжийг сайжруулах олон талт арга хэмжээг хэрэгжүүлж байгаа нь хүүхэд, өсвөр үеийнхний эрүүл мэндийг сайжруулахад томоохон хувь нэмэр болж байна.

Эрүүл мэндийн бүртгэл зүйн мэдээгээр 10 000 хүүхдэд ногдох өвчлөл нялхсын хувьд 48,5, нэгээс дөрөв хүртэлх насанд 72,3, таваас арван таван насанд 126,7, арван зургаагаас арван есөн насанд 66,8 тохиолдож байна. Мөн ерөнхий боловсролын сургуулийн 1000 сурагч тутмаас 678,2 нь ямар нэг архаг өвчтэй, өсвөр насны охидын 9 хувь нь жирэмсэлсэн судалгааны дүн мэдээ байна.

**1.1.1.1.** Хүүхдийн эндэгдэл буурч байгаа ч ураг нярайн болон нялхсын эндэгдэл олон аймагт улсын дунджаас дээгүүр байна. Амьдралын түвшин доогуур өрхийн хүүхэд 2,5 дахин илүү өвчилж, 3 дахин илүү эмнэлэгт хэвтэж, мөн төдий тоогоор эндэж байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Хүүхэд, өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын орчин нөхцөл, технологийг сайжруулахад хүрэлцэхүйц хэмжээтэй хөрөнгө оруулалтыг шаардаж байна. Хүүхэд, өсвөр үеийнхэнд үзүүлж буй эрүүл мэндийн анхан шатны тусламж шаардлагын түвшинд хүрч чадаагүй, хүүхдийн эмч бэлтгэх, мэргэшүүлэх бодлого алдагдсан байна.

Сүүлийн арваад жилд хүүхдийн эмчийн тоо 3,5 дахин цөөрсөн төдийгүй нийт аймгийн дөнгөж 25 хувь нь хүүхэд, өсвөр үеийн эрүүл ахуйн эмчтэй байна.

**1.1.1.2.** Хүүхдийн эсэн мэнд амьдрахын үндэс болсон хоол хүнсний чанар хүрэлцээ, хангамж ДЭМБ-ын зөвлөмжийн нийтлэг жишиг хэмжээнд хүрэхгүйгээс тав хүртэлх насны хүүхдэд тураал 12,5 хувь, өсөлтийн хоцрогдол 24,6 хувь, Д аминдэм дутлын рахит 32,1 хувь, цус багадалт 40,2 хувь тохиолдож байна. Мөн таваас дээш насны хүүхэд, өсвөр үеийнхний 16 хувь нь өсөлтийн хоцрогдолтой, 21,4 хувь нь иод дутлын эмгэгтэй байна.

Байгалийн гамшиг, хүрээлэн буй орчны бохирдол, хүний ухамсарт үйлдлээс үүдсэн эрсдэлт байдлаас хүүхэд, өсвөр үеийнхний эрүүл мэнд, амь нас хохирох тохиолдол гарсаар байна. Өсвөр үеийнхний дунд тохиолдох осол гэмтэл, цочмог хордолт насанд хүрэгчдийнхээс 2 дахин илүү байна.

**1.1.2. Хүүхдийн сурч боловсрох эрх.** Сүүлийн жилүүдэд боловсролын тогтолцоог шинэчлэн өөрчлөх, сургалтын арга хэлбэрийг боловсронгуй болгох, төвлөрлийг сааруулах чиглэлээр нэлээд өөрчлөлт хийгдсэн боловч ерөнхий боловсролын сургуулийн хүртээмж хангалтгүй хэвээр байна.

2000 оны байдлаар улсын хэмжээнд 280,0 мянган суудал бүхий 683 ерөнхий боловсролын сургуульд 494,5 мянган хүүхэд суралцаж, анги дүүргэлт 45-50 хүүхэд болж ЕБС-ийн сургалт дунджаар 2,7 ээлжтэй, зарим сургууль 3 ээлжтэй байна /Хүүхдийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилтийн талаархи Засгийн газрын илтгэл/.

ХЭҮК-оос хийсэн судалгаанд төвлөрсөн хот суурин газруудын сургуулийн ачаалал өндөр байгаа нь хүүхдийн сурч боловсрох эрх, сурлагын чанарт муугаар нөлөөлж байна гэсэн дүгнэлт хийгдсэн. Нийслэлд 2001-2002 оны хичээлийн жилд 154 ерөнхий боловсролын сургууль хичээллэж, анги дүүргэлт 34 болж, нэг ангид суралцаж буй хүүхдийн тоо өмнөх оныхоос 5,5 хувиар буурсан нь хувийн хэвшлийн сургуулийн эзлэх хувь 39,0 хувь болж өссөнтэй холбоотой байна гэж нийслэлийн Засаг даргын Статистик, мэдээлэл судалгааны газрын мэдээлэлд тэмдэглэгджээ.

Хэдийгээр нийслэл болон зарим төв, суурин газарт ерөнхий боловсролын хувийн сургуулиуд нэмэгдэж байгаа нь сургуулийн анги дүүргэлт, ачааллыг багасгах ач холбогдолтой боловч нэг сурагчаас авч буй сургалтын төлбөр харилцан адилгүй,

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

зарим сургуульд хэт өндөр байгаа нь анхаарал татаж байна. Тухайлбал, “MCS” компаний “Орчлон” сургууль нэг сурагчаас жилд 950 долларын төлбөр авдаг нь хамгийн өндөр байгаа бөгөөд их сургуулийн төлбөрөөс даруй 3 дахин их байна. Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулиар сургуулийг ашгийн төлөө бус байгууллага гэж тодорхойлсон ч бодит байдлаас харахад зарим сургуулиуд эргэлзээ төрүүлж байна. Түүнчлэн 400-500 долларын төлбөртэй сургууль ч байна. Иймд хувийн сургуулиудын төлбөр хураамжийн үндэслэл, зарцуулалт, сургалтын арга барил чанарт тавих мэргэжлийн хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

**1.1.2.1.** ЕБС-ийн хүртээмж бага, ачаалал маш өндөр байгаа нь сурагчдын сурлагын чанарт муугаар нөлөөлөөд зогсохгүй хичээлээс гадуур соёл, хүмүүжлийн ажил зохиох, мэргэжлийн дугуйлан секц ажиллуулах, сурагчдын авьяас чадварыг нээн хөгжүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээ зохион байгуулах  боломжийг хааж, сурагчид чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөхөд муугаар нөлөөлж байна. ЕБС-ийн ачааллыг багасгах, шинээр сургууль барьж байгуулах, өргөтгөх, хувийн бага сургууль байгуулах үүсгэл санаачилгыг дэмжих, урамшуулах талаар Засгийн газраас хөрөнгө хүч гаргах шаардлагатай байна.

**1.1.2.2.** Хүүхдэд суурь боловсрол олгох, сургууль завсардалтыг багасгахад сурагчдын дотуур байрны хангамж, хүрэлцээ чухал ач холбогдолтой хэвээр байна. 1990 оны үеэс сургуулийн сурагчдын дотуур байрны хэвийн үйл ажиллагаа алдагдаж, дотуур байрны зардлыг эцэг, эхээс нь гаргуулж байсан ба ихэнх сумдын дотуур байр хэвийн ажиллаж чадахгүйд хүрсэн. 1990 оны үед нийт сурагчдын 14,5 хувь дотуур байранд хамрагдаж байсан бол 1996 он гэхэд 4,1 хувь болтлоо буурсан.

Харин 1997 оны үеэс эхлэн дотуур байрны сурагчдын тоо өсч 2001-2002 онд 41448 хүүхэд дотуур байранд орох шаардлагатайгаас 27978, 2002-2003 оны хичээлийн жилд 43927 хүүхэд дотуур байранд амьдрах шаардлагатайгаас 33378 хүүхэд дотуур байранд хамрагдаж, 2002-2003 оны хичээлийн жилд зарим аймгуудад дотуур байранд суугчдын тоо харьцангуй нэмэгджээ.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Сурагчдын дотуур байрны нөхцөл, хангамж шаардлагын хэмжээнд хүрэхгүй, ихэнх дотуур байр өвлийн улиралд хэвийн ажиллах боломж, нөхцөлөөр муу байгаа нь судалгаанаас харагдаж байна.

**1.1.2.3.** Сургууль завсардалт дорвитой буурахгүй байна. Сургууль завсардалтын талаархи мэдээ судалгаа ихээхэн зөрүүтэй байдаг. Хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрт улсын хэмжээнд суурь боловсрол эзэмшвэл зохих насны /8-15/ хүүхдийн 13,5 хувь нь буюу 68155 хүүхэд сургуульд суралцаж чадаагүй, сургууль завсардалт хөдөө, орон нутагт 20,0 хувьтай байна гэж тэмдэглэгджээ.

1999-2000 онд 12167 хүүхэд, 2000-2001 онд 13751 хүүхэд сургууль завсардсаны 10963 нь хөдөө байна. /БСШУЯ-ны мэдээнээс/

ХЭҮК, Хүүхдийн төлөө үндэсний газар, Монголын хүүхдийн эрхийн төвөөс хийсэн судалгаагаар Дорноговь, Баян-Өлгий, Увс, Дархан-Уул, Булган аймгуудад ерөнхий боловсролын сургуульд хамран сургалт 91-94 хувьтай гарсан. Дорнодод 1955, Баян-Өлгийд 1879, Увсад 1638, Завханд 950, Төв аймагт 867 хүүхэд сургууль завсардсан байв. Сургууль завсардсан хүүхдүүдийн дийлэнхийг нь хөдөөгийн малчдын болон ядуу амьдралтай өрхийн, төв суурин газарт зохих зөвшөөрөлгүй оршин суугчдын хүүхдүүд эзэлж байна.

Өнгөрсөн онд ХЭҮК-оос нийслэл хотын зөвхөн Сонгинохайрхан, Баянзүрх дүүрэгт зөвшөөрөлгүй оршин сууж буй иргэдийн дунд хийсэн судалгаагаар 4754 өрхийн 633 хүүхэд сургууль завсардсан болох нь тогтоогдож байв.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**1.1.2.4.** Хүүхдээ сургуулиас нь гаргаж авах, сургуульд оруулахгүй байх явдал малчдын дунд өсөх хандлагатай болов. ОУХБ-ын "АЙПЕК" хөтөлбөрийн хүрээнд 4 аймгийн хэмжээнд Нийгмийн хөгжлийн төвөөс хийсэн судалгаанд мал маллаж буй 291 хүүхэд хамрагдсан ба тэдний 53,8 хувь сургууль завсардсан, 8,3 хувь нь огт сургуульд суугаагүй байсан байна.

Ядуу амьдралтай, амьжиргааны баталгаажих доод түвшингээс доогуур орлоготой өрхийн сургуулийн насны хүүхдүүд олон тоогоор сургуулиас завсардсаар

байхад тэдэнд орон нутгийн засаг, төрийн байгууллагууд тусалж дэмжих талаар хангалтгүй анхаарч байна.

Ховд аймгийн Мөст сумын “Улаан толгой” багийн иргэн, өрх толгойлсон эмэгтэй “Н” нь 4 хүүхэдтэй, айлын зуны пинд амьдардаг, сургуулийн насны 3 хүүхэдтэй бөгөөд хувцас, хичээлийн хэрэглэлгүй тул гурвуулаа сургууль завсардсан. Төсөв хүрэлцээгүйгээс сумаас ямар нэг дэмжлэг туслалцаа үзүүлэх боломжгүй /Ховд аймгийн судлаачийн тайлангаас/. Иймэрхүү жишээ баримт олон байна.

**1.1.2.5.** Насанд хүрээгүй хүмүүсийн хорих ангид жил бүр 150-200 хүүхэд ирдэг бөгөөд тэдний 60-аад хувь нь 1-7 дугаар ангиас сургууль завсардсан, 30 хувь нь огт бичиг үсэг мэддэггүй хүүхдүүд байдаг байна /Хорих ангийн даргын илтгэлээс. 2003.02.18/.

**1.1.2.6.** Судалгаанаас үзэхэд ядуу иргэдийн хүүхдүүд болон хараа хяналтгүй хүүхдүүд их хэмжээгээр сургуулиас гарч, завсардаж байна. Сурагчдаас элдэв төрлийн шалтгаанаар мөнгө төгрөг хурааж авдаг, хувцас хунар шаарддаг нь ядуу өрхийн хүүхдүүд сургуулиас хөндийрөх, завсардахад нөлөө үзүүлдэг.

Нийслэлд 290 хүүхдийн дунд явуулсан санал асуулгаар сургуулийн захиргаа, багш нарын зүгээс мөнгө, эд зүйл байнга шаарддаг гэж 23,0 хувь нь, хааяа шаарддаг гэж 58,4 хувь, орон нутагт хийгдсэн судалгаанд хамрагдсан 2113 хүүхдийн 69,4 хувь нь, эцэг, эхийн 57,8 хувь нь мөнгө, эд зүйл байнга шаарддаг гэж хариулжээ. Түүнчлэн ЕБС-ийн хүрээнд ном, сурах бичиг, гарын авлага, үзвэрийн билетийг тулгаж зардаг, авахыг шаарддаг, хичээлээс хожигдох, таслахад мөнгө хураадаг болсон талаар иргэд тогтмол гомдол, санал гаргаж байдаг.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**1.1.2.7.** Улсын хэмжээгээр тахир дутуу буюу оюуны хомсдолтой 34000 гаруй хүүхэд байдаг гэсэн судалгаа бий. Эдгээр хүүхдүүдэд зориулагдсан тусгай сургууль 5 байдаг бөгөөд 2000 орчим хүүхэд суралцдаг байна.

Хөдөө, орон нутагт амьдардаг тахир дутуу буюу оюуны хомсдолтой хүүхдүүд сургуульд суралцах, суурь боловсрол эзэмших боломж туйлын хязгаарлагдмал

байдаг учир ихэвчлэн сургууль завсарддаг. Хөдөө, орон нутгийн харах, сонсох болон ярих эрхтэний доголдолтой буюу оюуны хомсдолтой хүүхдүүдийн сурч боловсрох эрхийг хангах, тусгай сургуулийн тоог нэмэгдүүлэх, хөдөөд энэ төрлийн сургалтыг ойртуулах арга хэмжээ үнэхээр үгүйлэгдэж байна.

**1.1.3. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт.** Монгол Улс ОУХБ-ын Аж үйлдвэрт ажилд авах насны доод хэмжээний тухай 59 дүгээр конвенци, Газрын доорх ажилд авах насны доод хэмжээний тухай 123 дугаар конвенци, Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хүнд хэлбэрийг хориглох болон устгах тухай 182 дугаар конвенцид нэгдэн орж, хүүхдийн хөдөлмөрийн тухай асуудлыг Хөдөлмөрийн тухай хуулийн /1999 он/ Наймдугаар бүлгээр зохицуулж, ажилд авах насны доод хязгаарыг 16 нас байхаар тогтоож, насанд хүрээгүй хүн ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтыг батлан гаргаж, хөдөлмөр эрхлэлтийн хүрээнд хүүхдийн эрхийг хамгаалах хэрэгжүүлэх чиглэлээр нэлээд ажил зохиож байна.

Гэвч ядуурал, ажилгүйдэлтэй холбоотойгоор бага насны болон насанд хүрээгүй хүмүүс эрүүл энх өсч хөгжихөд сөрөг нөлөөтэй хүнд, тэвчишгүй хэлбэрийн ажил хөдөлмөр эрхлэх нь бага биш байна.

**1.1.3.1.** Улсын хэмжээгээр албан болон албан бус салбарт хичнээн хүүхэд хөдөлмөр эрхэлдэг болох талаар нэгдсэн тоо баримт байдаггүй. НХХЯ "Хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн ажлын нөхцөлийн талаар судалгаа хийгдсэн боловч албан бус салбарт хичнээн хүүхэд хөдөлмөр эрхэлдэг талаар тодорхой тоо байхгүй, харин сургууль завсардсан хүүхдийн тоогоор багцаалж болно" гэж нийтэд мэдээлсэн /Зууны мэдээ, 2002- 6-12, №145/.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

ХЭҮК болон төрийн бус байгууллагуудаас нийслэл болон хөдөө, орон нутагт хийсэн судалгаанаас үзвэл хүүхдүүд эрүүл мэнддээ сөрөг нөлөө үзүүлж болох доорхи төрлийн ажил хөдөлмөрийг эрхэлж байна.

**1.1.3.1.1.** Сүүлийн жилүүдэд алтны ордуудад насанд хүрээгүй хүмүүс томчуудын нэгэн адил шороо зөөж ухах, ачиж буулгах, чулуу бутлах, мөнгөн ус зэрэг хорт бодистой харьцаж ажиллах нь түгээмэл болсон нь анхаарал татаж байна.

Хамгийн аюултай нь алтны уурхайд албан бусаар хөдөлмөрлөж буй хүүхдүүд хүний эрүүл мэндэд хорт нөлөө үзүүлдэг мөнгөн устай харьцаж ажилладаг байна. ОУХБ-ын "АЙПЕК" хөтөлбөрийн хүрээнд Төв, Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн нутагт байдаг үндсэн ба шороон ордны 17 уурхайд хувиараа алт олборлодог 59 хүн, үүний дотор 11-18 насны 17 хүүхдийн дунд НЭМХ-ээс хор судлалын шинжилгээ хийхэд, судалгаанд хамрагдсан 17 хүүхдийн 8 нь мөнгөн усны архаг хордлоготой, тэдний 7 нь мэдрэлийн сульдааны хам шинжийн өвчтэй болсон байна. Эдгээр уурхайнуудад ажилладаг 122 хүүхдийн дунд мөнгөн устай харьцаж ажилладаг хүүхэд 37,7 хувийг эзэлж байжээ. Тэнд ажилладаг эмэгтэйгээс мөнгөн усны хордлоготой, бие эрхтэний согогтой хүүхэд төрсөн талаар дээрх судалгааны тайланд тусгагджээ.

Хувиараа алт олборлогчдоос бэртэж, гэмтсэн осол аваарт орсон, эрүүл мэндээрээ хохирсон тохиолдол цөөнгүй гардаг байна. 2000-2002 онд Борнуурт 3 удаа, Баруунхараад 4 удаа осол гарсан байна.

**1.1.3.1.2.** Хүүхдүүд осол аваарт өртөж болзошгүй газрын гүнд, нүх цооногт ажиллах, чулуу бутлах хүнд хүчир хөдөлмөрийг эрхэлж, хүүхдийн өргөх ачааны зөвшөөрөгдөх/ эрэгтэй хүүхэд 8-16 кг, эмэгтэй хүүхэд 5-10 кг/ хэмжээнээс 2-3 дахин хүнд шороо, чулуу байнга зөөх нь элбэг байна.

Нийслэлийн Налайх дүүргийн нүүрсний уурхайд 200-300 хүүхэд тогтмол ажиллаж /тэднийг хүмүүс "болжмор", "хэрээ" гэж нэрлэдэг/, нүүрс чирж гаргах, шигших, түүх зэрэг хүнд хортой хөдөлмөр эрхэлдэг.

**1.1.3.1.3.** Нийслэлийн зургаан дүүргийн том, бага нийлсэн 31 зах дээр 1000 гаруй хүүхэд хөдөлмөр эрхэлдэг гэсэн баримжаа тоо бий. Нийслэлийн зарим дүүргүүдийн зах дээр ажилладаг 300 хүүхдийн /64,3 хувь нь эрэгтэй, 35,7 хувь нь эмэгтэй/ дунд судалгаа хийхэд тэдний 58,7 хувь нь сургууль завсардсан, 45,3 хувь нь өвчин эмгэг тусч, 39,0 хувь нь ямар нэг бэртэл гэмтэл авч байсан байна.

Зах дээр хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдэд томчуудын зүгээс дээрэлхдэг, хөлс мөнгөө дутуу өгдөг, том хүүхдүүдэд зодуулах, дээрэмдүүлэх зэрэг дарамт бэрхшээл байнга гардаг гэж санал асуулгад оролцсон хүүхдүүдийн дийлэнх хариулсан байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Судалгаанд хамрагдагсдын 74 хувь нь захын байцаагчид, 29,3 хувь нь атаманд, 4,9 хувь нь захын цагдаад олсон орлогоосоо ямар нэгэн хэмжээгээр татвар, хураамж төлдөг гэж хариулжээ.

**1.1.3.1.4.** Монголын уламжлалт мал аж ахуй, ёс заншилтай холбоотой зарим асуудлууд ч хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй буюу хүнд хөдөлмөрт тооцогдох эсэх талаар сүүлийн үед ихээхэн яригдах болсон. Энэ нь ч зүй ёсны хэрэг.

Сүүлийн жилүүдэд суурь боловсрол эзэмшвэл зохих насны олон мянган хүүхдүүд хөдөө, орон нутагт янз бүрийн хэлбэрээр хөдөлмөр эрхэлж байна. Хүүхдүүд өөрсдийн эцэг, ах, дүүгийн хамтаар мал маллаад зогсохгүй, ядуу амьдралтай өрхийн хүүхдүүд олон малтай айл өрхөд хөлстэй, хөлсгүй зарагдах явдал түгээмэл болсон байна. 2001 онд Өвөрхангай, Ховд аймгуудын 12 сумын 225 малчин өрх, 122 ажил олгогч өрхийн 291 хүүхдийг хамруулан судалгаа хийхэд судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 54,6 хувь нь гэртээ буюу хамаатан садныдаа, 45,4 хувь нь айлд мал малладаг, 58,3 хувь нь сургууль завсардсан хүүхдүүд байсан ба ажил олгогч өрхийн 57,4 хувь нь 201-500, 3,3 хувь нь 500-аас дээш толгой малтай өрхүүд байжээ /ОУХБ-ын “АЙПЕК” хөтөлбөрийн хүрээнд НХТ-ийн хийсэн судалгаанаас/.

Айлд мал маллаж байгаа хүүхдүүд ихэнхдээ аман тохиролцоогоор ажилладаг ба судалгаанд хамрагдагсдын 1,5-6,1 хувь нь бичгийн гэрээтэй гэх боловч ийм гэрээг үзүүлж чадаагүй ба айлд мал маллаж байгаа хүүхдийн 54,3 хувь нь хөлс, шан харамж авдаг гэж, 45,7 хувь нь хөлс авдаггүй гэж хариулжээ. ХЭҮК-оос 2003 онд хийсэн судалгаагаар Завханд 743, Өмнөговьд 650, Баянхонгорт 3500, Говь-Алтайд 522 хүүхэд мал аж ахуйн салбарт ажилладаг гэсэн мэдээ байна.

Дорнод аймгийн Баянтүмэн суманд л гэхэд 7-16 насны 12 хүүхэд айлд мал малладаг байна /Сумын нийгмийн ажилтны ярианаас/.

Эдгээр тоо баримтаас ядуу амьдралтай өрхийн хүүхдийн хөдөлмөрийг ямар ч гэрээ хэлцэлгүйгээр, цалин хөлсгүйгээр ашиглаж, завших, тэд боловсрол эзэмших,

UIH.MN СУДАЛГААНЫ САН

сурч боловсрох эрхээ эдэлж чадахгүй хохирох хандлага газар авч байна гэсэн дүгнэлт хийж болох байна.

Энэ нөхцөлд төр, засгийн зүгээс онцгой анхаарал тавьж орон нутгийн засаг захиргааны болон хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагаас тавих хяналтыг хүчтэй болгох, нөхцөл байдлыг сайтар хянах судлах шаардлагатай болжээ.

**1.1.3.1.5.** Уралдааны хурдан морь унаж буй хүүхдийн эрхийн асуудалд олон нийтийн зүгээс шүүмжлэлтэй хандах явдал нэлээд гарах болов.

Монголын уламжлалт хурдан морины уралдааны зорилго, хамрах хүрээ ихээхэн өөрчлөгдөж, зах зээлийн шинж төрхтэй болж, баяр наадам, ой тэмдэглэх үйл ажиллагаа, бооцоот уралдааны тоо ихэсч, өвөл зунгүй хурдан морины уралдаан зохиогддог болсон. Тойм байдлаар авч үзэхэд жилдээ 40-50 баяр наадам болж, морь уралдуулж, 2000 орчим хүүхэд морь унадаг гэсэн баримжаа байдаг байна.

Уралдааны морь унах нь хүүхдийн хөдөлмөр мөн эсэх талаар маргаан мэтгэлцээн байдаг. Морь уях үеэр өглөөнөөс үдэш хүртэл хүүхдүүд морьтойгоо ажиллаж, идэш хоол, уяаг нь тааруулж, унаж үсэргээ сунгаанд оролцож, гэр орноосоо тусгаарлагдан, халуунд халж, хүйтэнд дааран байж, уралдааны үед 15-30 км зайд бартаатай тоос шороотой замаар, нүүр нүдгүй булуулан, заримдаа унаж бэртэн байж уралддагийг харахад хурдны морь унахыг хүүхдийн хөдөлмөр гэж үзэхээс өөр аргагүй.

Бага насны хүүхдүүд хурдан морь унах нь түүний амь нас, эрүүл мэндэд бодит эрсдэлтэй байна. Зөвхөн 2001 оны Ардын хувьсгалын 80 жилийн ойн баяр наадмаар уралдсан их нас, азарганы уралдааны үеэр 49 хүүхэд мориноосоо унаж хүнд, хөнгөн хэлбэрээр бэртсэн, 1999 оны Улсын баяр наадмаар 1 хүүхэд амь насаа алдсан баримт байна.

Монголын Хуульч эмэгтэйчүүдийн холбооноос хурдан морь унадаг 50 хүүхдийн дунд явуулсан судалгаагаар тэдний 68,0 хувь нь 10-15 насны, 32,0 хувь нь 6-9 насны хүүхдүүд байсан ба уяачид, хүүхдүүдийн 68,9 хувь нь хурдан морь унаж байгаа хүүхдийн аюулгүй байдалд үргэлж санаа зовдог гэж хариулжээ.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Хурдан морь унадаг хүүхдийн хөлс, урамшууллын тухайд ч анхаарч үзэх шаардлагатай болсон. Хурдан морины хүүхдийн тухай асуудлыг уламжлалт ёс заншил хэмээн үзэж, тэдний эрүүл мэнд, амь насны талаар анхааран авч үзэхгүй, төрийн зүгээс ямар ч зохицуулалтгүй явж ирснийг хүүхдийн эрхийн ноцтой зөрчил гэж үзэж байна. Хурдан морь унах хүүхдийн насны доод хязгаарыг тогтоох, тэдний амь нас, бие эрхтэнд нь учирч болох эрсдлийг багасгах, аюулгүй ажиллагааг хангах, морины эзэн болон хүүхдийн хоорондын хөдөлмөрийн харьцааг зохицуулах, даатгалд хамруулах зэрэг асуудлыг судлан үзэж, эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.

**1.1.3.1.6.** Насанд хүрээгүй хүмүүс /16-18/ үйлдвэр, аж ахуйн газруудад хөдөлмөрийн гэрээгээр ажиллах нь цөөнгүй байна. Насанд хүрээгүй хүмүүсийн хөдөлмөрийн харьцааг хөдөлмөрийн хуульд тусгайлан заасан боловч энэхүү заалт амьдралд тэр бүр хэрэгжихгүй байна. ХЭҮК-оос нийслэл болон Дархан-Уул аймгийн гадаадын хөрөнгө оруулалттай 24 үйлдвэрт хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд тэднийг тогтоосон хугацаанд эрүүл мэндийн үзлэгт хамруулдаггүй, илүү цагаар болон хөдөлмөрийн хуульд зааснаас илүү хугацаагаар ажиллуулдаг зэрэг зөрчил илэрч байсан.

Дорнод аймгийн “Шинхуа” ХХК-д 17-18 насны охид хөвгүүдийг эрүүл ахуйн шаардлага хангаагүй байранд шөнийн цагаар ажиллуулдаг байна /Дорнод аймгийн судлаачийн тайлангаас/.

**1.1.4. Хүүхдийн гэмт хэрэг.** Хууль тогтоомжоор насанд хүрээгүй хүмүүсийн үйлдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах, шүүн таслах тусгай зохицуулалттай бөгөөд тэднийг цагдан хорих, ял эдлүүлэх тусгай төрөлжсөн байгууллагуудтай байна.

**1.1.4.1.** Насанд хүрээгүй хүмүүсийг гэмт хэрэг, хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хараа хяналтгүй, тэнэмэл хүүхдийг асрамж халамжтай болгох, багасгах талаар орон нутгийн засаг захиргааны болон цагдаагийн байгууллагаас багагүй ажил зохиож, ихээхэн хөрөнгө хүч зарцуулдаг байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Гэвч гэмт хэрэгт холбогдсон насанд хүрээгүй хүмүүс болон хараа хяналтгүй хүүхдийн тоо харьцангуй их байна. Цагдаагийн Ерөнхий Газраас гаргасан мэдээгээр 2001 онд улсын хэмжээгээр 1147 гэмт хэрэгт 1675 хүүхэд холбогдсон бол 2002 онд 1059 хэрэгт 1703 хүүхэд холбогдож, гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн тоо 1,6 хувиар өссөн байна. Гэмт хэрэг үйлдсэн нийт хүүхдүүдийн 70 гаруй хувь нь Улаанбаатарт байдаг. Насанд хүрээгүй хүмүүсийн үйлдэж байгаа гэмт хэргийг төрлөөр нь авч үзвэл хэрэгт холбогдогчдын бараг 70 орчим хувь нь бусдын өмчийн эсрэг тухайлбал, хулгайн гэмт хэрэгт холбогджээ.

**1.1.4.2.** Шүүхийн статистик мэдээгээр 2000 онд 990, 2001 онд 1034, 2002 онд 1162 насанд хүрээгүй хүмүүс ял шийтгүүлсэн. Гэмт хэрэгт холбогдож шүүхээр ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүмүүсийн 10 гаруй хувьд нь хорих ял оноодог бөгөөд хүүхдийн хорих ангид жил тутам 150-200 шахам хүүхэд ирж хүмүүждэг.

**1.1.4.3.** Хорих ангид ирж хүмүүжиж буй хүүхдүүдийн 70 орчим хувь нь огт бичиг үсэг мэддэггүй, 60-аад хувь нь сургууль завсардсан, 10-15 хувь нь бүтэн өнчин, орон гэргүй тэнэмэл хүүхдүүд байна.

Хорих ял шийтгүүлсэн хүүхдүүд ялынхаа тал хувийг эдлээд магадлангаар орж хугацаанаасаа өмнө тэнсэн суллагддаг байсан бол шинэ Эрүүгийн хууль хэрэгжиж эхэлснээс хойш тэд хугацаанаасаа өмнө тэнсэн суллагдах магадлал тун хомс болжээ. Уг хуулийн 74.4-д зааснаар: учруулсан хохирлоо нөхөн төлөөгүй бол хугацаанаас өмнө тэнсэн суллах журмыг хэрэглэхгүй гэжээ. Тэдний дийлэнх нь өмчийн эсрэг гэмт хэрэгт шийтгүүлж, учруулсан хохирлоо нөхөн төлөөгүй, төлөх ч чадваргүй байдаг.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Гэмт хэрэгт холбогдож, ял эдэлж суллагдсан хүүхдүүдийг нийгэмд байр сууриа олох, ажил мэргэжилтэй болоход нь төрөөс тусгайлан авч үзэж, тусалж дэмжих талаар онцгой анхаарах шаардлагатай байна.

"Би хулгай хийхгүйгээр амьдарч чадахгүй, амьдрал надаас хулгай хийхийг шаардаж байна, надад гэр орон байхгүй, би хаачих юм бэ, би дахиад л хулгай хийж

шоронд орох байх” гэж 18 настай хүү ярьсан байна /ХЗДХЯ, ЦЕГ, ХЭҮК, МӨХ-ноос хийсэн судалгааны тайлангаас/.

**1.1.4.4.** Судалгаанаас үзэхэд насанд хүрээгүй хүмүүст оноож байгаа хорих ялын хувийн жин насанд хүрэгчдийнхээс доогуур байгаа хэдий ч Хүүхдийн эрхийн тухай конвенцийн заалтын дагуу насанд хүрээгүй хүмүүст онцгой, гарцаагүй тохиолдолд л хорих ял оноож байх бодлогыг шүүх баримтлах шаардлагатай байна.

Анх удаагаа онц хүнд биш гэмт хэрэгт холбогдсон хүүхдүүдэд хорих ял оноосон тогтоол биелүүлэхийг түдгэлзүүлэх, хорихоос өөр ял оноох хуулийн заалтыг өргөн ашиглах хэрэгтэй байна.

Гэмт хэрэг зөрчилд холбогдсон хүүхдүүд нь ихэвчлэн амьдралын түвшин доогуур, бүтэн өнчин буюу хагас өнчин хүүхдүүд байдаг бөгөөд тэдний өмгөөлөгч авч эрх зүйн туслалцаа авах эрх нь ихээхэн хязгаарлагдмал байна. ХЭҮК-оос 2001 онд хийсэн судалгаанаас үзэхэд Ганц худагт хоригдож буй 70 орчим хүүхдийн 60 орчим хувь нь огт өмгөөлөгч аваагүй байсан.

Шинээр мөрдөгдөж буй ЭБШ хуулиар хөнгөнөөс бусад бүх төрлийн гэмт хэрэгт хүүхдүүдийг цагдан хорьж болохоор байгаа ба хорьж мөрдөх дээд хугацааг бүтэн 1 жил 6 сараар тогтоосон нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай пакт, Хүүхдийн эрхийн тухай конвенцийн “Цагдан хорих арга хэмжээг онцгой тохиолдолд хэрэглэх, хэргээ аль болох ахар богино хугацаанд хянан шийдвэрлүүлэх эрхтэй” гэсэн зарчимтай зөрчилдөж байна.

Гэмт хэрэгт холбогдсон хүүхдүүдийн хэргийг богино хугацаанд таслан шийдвэрлэх, онц шаардлагагүй тохиолдолд цагдан хорихоос түдгэлзэх, өмгөөлөгч авах эрхийг нь ойлгуулах, тийм нөхцөл боломжоор хангах талаар хуулийн байгууллагууд онцгой анхаарах шаардлагатай байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**1.1.5. Хараа хяналтгүй хүүхэд.** Нийслэлийн Цагдаагийн газрын Хүүхдийн хаяг тогтоох газрын мэдээгээр 2000 онд 1795, 2001 онд 1829, 2002 онд 1279 хараа хяналтгүй тэнэмэл хүүхдийг хүлээн авч хаягийг нь тогтоох ажиллагаа явуулж эцэг, эх, асран хамгаалагчид болон асрамж, халамжийн байгууллагад шилжүүлжээ.

Түүнчлэн улсын хэмжээнд 231 хүүхэд орон гэрээсээ дайжин, хараа хяналтгүй тэнэж явaa гэсэн мэдээг тус газар гаргажээ.

Хараа хяналтгүй тэнэмэл гэгдэх хүүхэд Дархан-Уул, Дорнод, Дундговь, Сэлэнгэ аймгуудад бусад аймгаасаа харьцангүй олон байна.

**1.1.5.1.** Хараа хяналтгүй тэнэж яваад хаяг тогтоох газарт ирсэн хүүхдийг авч хүмүүжүүлэх газар нь хүүхдийн асрамж халамжийн төвүүд байдаг. Улаанбаатар хотод 27, Дорнод, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ, Төв аймагт 10 орчим хүүхдийн асрамж халамжийн төвүүд үйл ажиллагаа явуулдаг байна. Тэдний дийлэнх олонхи нь гадаадын байгууллага, иргэдийн санхүүжилтээр ажилладаг.

Хүүхдийн хаяг тогтоох газар тэнэмэл хүүхдийн тухайд чухал үүрэг гүйцэтгэдэг хэдий ч ахуй нөхцөл, боловсон хүчин, хангамжийн хувьд төдийлөн сайн биш байна. Хараа хяналтгүй хүүхдийг албадан саатуулах тухай хуулиар /1994 он/ тэдгээр хүүхдийг 7 хүртэл хоногоор албадан саатуулахаар заасан нь ямар нэгэн гэмт хэрэг зөрчилд холбогдоогүй, гэм буруугүй байхад хүүхдүүдийг ингэж олон хоногоор албадан саатуулж байгаа нь тэдний халдашгүй чөлөөтэй байх эрхийг зөрчиж байна.

**1.1.5.2.** ХЭҮК, Хүүхдийн төлөө үндэсний газраас 2003 оны эхээр хийсэн судалгаагаар улсын хэмжээнд асрамж, халамжийн 37 байгууллагад 1606 хүүхэд хүмүүжиж байгаагийн 758 нь бүтэн буюу хагас өнчин, 171 нь эцэг, эхтэйгээ таарамжгүйн улмаас, 124 нь хойд эцэг, эхтэйгээ таарамжгүйн улмаас, 171 нь эцэг, эх нь ял эдэлж байгаагаас асрамж, халамжийн төвд ирсэн хүүхдүүд байсан байна. Нийслэлийн асрамж, халамжийн 27 байгууллагад 1262 хүүхэд хүмүүжиж байна.

Манай бизнесийн салбарынхан элдэв төрлийн ой, тэмдэглэлт үйл явдал, алдар цолтнуудыг ивээн тэтгэх, хөрөнгө мөнгө гаргах нь их байдаг хэдий ч хараа хяналтгүй, эцэг, эхгүй болон ядуучуудын хүүхдүүдэд хөрөнгө оруулалт хийх, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх нь цөөн байна. Тэдний хүч туслалцааг нийгмийн энэ салбарт чиглүүлэхэд анхаарах хэрэгтэй байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулинд улсын асрамжид хүмүүжиж байгаад 18 насанд хүрсэн өөрийн гэсэн эд хөрөнгөгүй хүүхдүүдэд улсаас орон байр олгох заалттай боловч энэ нь амьдралд хэрэгждэггүй.

**1.1.5.3.** Орон гэргүй буюу орон гэрээсээ дайжсан охидууд биеэ үнэлэх явдал бодит байдал болсон. Биеэ үнэлдэг охидын талаар олон янзын тоо байдаг хэдий ч ЦЕГ-аас гаргасан судалгаагаар улсын хэмжээгээр насанд хүрээгүй 119 охид биеэ үнэлдэг гэсэн мэдээ бий. Хамгийн харамсалтай нь бага насны буюу 11-16 насны охид биеэ үнэлэх явдал нэлээд байдаг бөгөөд тэднийг ихэвчлэн насанд хүрэгчид зохион байгуулж удирддаг, зочид буудал, баар, цэнгээний газрууд боломж олгодог байна. Биеэ үнэлэх явдлыг зохион байгуулсан, орон байраар хангасан, боломж олгосон хүмүүсийг илрүүлэх, хариуцлага хүлээлгэх, биеэ үнэлэгч охидуудад ухуулга, сурталчилгаа хийх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

**1.1.6. Гэр бүлийн орчин.** Хүүхэд эрх чөлөөтэй, эрүүл энх өсч, хөгжихөд гэр бүлийн орчин буюу эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч онцгой үүрэгтэй билээ.

Эцэг, эхчүүд гэрлэлтээ цуцлуулах, гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлэх, архинд орох, ажилгүй болох тохиолдол бүрийн цаана хүүхдийн эрх ашиг хөндөгдөж байна. Иймээс гэр бүлийг бэхжүүлэх, эцэг, эхийн асран хүмүүжүүлэх үүргээ биелүүлэх ухамсрыг дээшлүүлэх, үүргээ биелүүлээгүй эцэг, эхтэй тооцох хариуцлагыг чангатгах хэрэгтэй байна.

**1.1.6.1.** Шүүхийн статистик мэдээнээс үзвэл гэр бүл салалт сүүлийн 4 жил дараалан өсчээ. 1999 онд 1425, 2000 онд 1517, 2001 онд 1657, 2002 онд 1803 гэр бүл гэрлэлтээ цуцлуулж, 2000 онд 899, 2001 онд 1371, 2002 онд 1125 хүүхдэд тэтгэвэр тогтоосон.

Тэтгэврийн хэмжээг 11 хүртэл насны хүүхдэд амьжиргааны баталгаажих доод түвшингийн хэмжээгээр, 11-16 насны хүүхдийг амьжиргааны баталгаажих доод түвшингийн хэмжээгээр тэжээн тэтгүүлэх хуультай ч, сүүлийн жилүүдэд хүүхдийн тэтгэлгийн төлөлт эрс доошилсон байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Нийслэлийн хэмжээнд гэхэд 2576 хүн шүүхийн шийдвэрээр хүүхдийн тэтгэлэг төлөх гүйцэтгэх хуудасны бүртгэлтэй боловч ихэнх нь хаяг дээрээ байхгүй, төлбөрийн чадваргүй гэсэн үндэслэлээр биелдэггүй байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хуулиар шийдвэр гүйцэтгэгчид биелүүлсэн төлбөрийнхөө 10 хувиар урамшуулал авахаар хуульчлагджээ. Харин хүүхдийн тэтгэлгийн тухайд шийдвэр гүйцэтгэгчид ямар нэгэн урамшил байхгүй учир тэд хүүхдийн тэтгэлгийг төлүүлэхээр нэг их хүч гаргадаггүй нь тодорхой. Хүүхдийн тэтгэлгийн төлөлтийг сайжруулах үүднээс эдгээр гүйцэтгэх хуудсыг биелүүлсэн шийдвэр гүйцэтгэгчид олгох шагнал урамшлыг тогтоож өгөх шаардлагатай байна.

**1.1.6.2.** Хараа хяналтгүй тэнэж, асрамж халамжийн байгууллагад хүмүүжиж буй нэлээд хүүхдүүд эцэг, эхтэй байна. Нийслэлийн асрамж, халамжийн төвд хүмүүжиж байгаа 1262 хүүхдийн 436 нь хагас өнчин, 447 нь эцэг, эхтэй хүүхдүүд юм.

Судалгаа хийх явцад зарим эцэг, эхчүүд гэр орноо зараад хүүхдээ орхиод сураггүй болсон тохиолдол ч гарсан. Төв аймгийн Баруун Зуун мод багийн иргэн “С” эхнэр нь нас барсны дараа, гэр орон, эд зүйлээ зараад хүүхдүүдээ хаяж явсан, 4-15 насны 4 хүүхэд нь айлын хашаа байшинд амьдарч байна. Саяхнаас хүүхдүүдийг нь дотуур байранд авчээ /Төв аймгийн судалгааны тайлангаас/.

Ийм маягаар үр хүүхдээ асарч хүмүүжүүлэх үүргээсээ зайлсхийсэн хүмүүст иргэний болон эрүүгийн хариуцлага хүлээлгэх, үүргээ биелүүлдэг болгох талаар хууль хяналтын болон хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагын ажлын уялдаа холбоог сайжруулах хэрэгтэй байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН